

МЭДЭГДЭЛ

Эрүүл мэндийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон Орхон аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар 2025 онд байгуулсан гэрээний бүтэн жилийн тайлан болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтийг “Монгол улсын Төсвийн тухай хууль” болон Эрүүл мэндийн салбарын Төсвийн Ерөнхийлөн захирагчид хуваарилагдсан төсөв, орон нутгийн төсвийн хүрээнд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, түүнийг хэрэгжилтийг хангах гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурлан гаргав.

Энэхүү тайлан нь эрүүл мэндийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны ажлын үр дүнг иж бүрэн, үнэн зөв илэрхийлсэн гэж үзэж байна.

ЗАСАГ ДАРГА

Б.ЗОРИГТБАЯР

2026 оны 01 дугаар сарын 13-ны өдөр

Тайланг хүлээн авсан Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн дүгнэлт:

1.-----

2.Орхон аймгаас ирүүлсэн тайланд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх шаардлагатай, шаардлагагүй /доогуур зурах/ гэж үзлээ
Тайланг хүлээн авсан:

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

Ж.ЧИНБҮРЭН

2026 оны 01 дугаар сарын 13-ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2025 ОНД БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Орхон аймаг

2026.01.13

№	Үндэслэж буй бодлогын баримт бичиг	Санхүүжлтийн эх үүсвэр /сая.төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилт
3.Хэрэгжүүлэгчийн эрх үүрэг							
1	3.1.Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө зэрэгт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэн гэрээний үр дүнг Захиалагчийн өмнө хариуцна.	-	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувь	93.8%	94%	Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө зэрэгт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг Орхон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2028 оны арга хэмжээний төлөвлөгөө, Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Орхон аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02/16 дугаар тогтоолоор батлагдсан “ Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай” арга хэмжээний төлөвлөгөө, Аймгийн Засаг даргатай байгуулсан Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн 2025 оны төлөвлөгөө, Эрүүл мэндийн газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусган, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангахад салбар дундын оролцоог ханган Эрүүл мэндийн газраас мэргэжил арга зүйн дэмжлэг сурталчилгаа, 65 удаагийн дэмжлэгт хяналт,зөвлөмжөөр тасралтгүй хангаж, хариуцлага хяналтыг сайжруулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Энэ хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах 2025 оны хамтын гэрээнд тусган хариуцлага хяналтыг сайжруулж, Удирдах ажилтны зөвлөгөөн 1, Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудын 12 удаагийн шуурхайг зохион байгуулж, мэдээллээр ханган, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 4, Засаг даргын зөвлөмөөр 5, Аймгийн Онцгой комиссын хурлаар 6, Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн 12 удаагийн хурлаар эрүүл мэндийн салбарын бодлого шийдвэрийн хэрэгжилт,тулгамдсан асуудлыг хэлэлцүүлэн Засаг даргын захирамж 31, Эрүүл мэндийн газрын даргын А тушаал 101, Б тушаал 42–ийг гарган хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, бодлого шийдвэрийн биелэлтийг	100

					хугацаанд нь И-оффисоор болон хэвлэмэл тайланг Эрүүл мэндийн яам, аймгийн Засаг даргын тамгын газарт нотлох баримтын хамт гаргаж хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу Эрүүл мэндийн газраас нэгтгэгдэн гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2025 оны хэрэгжилт, шалгуур үзүүлэлтэд сар, улирал, хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ хийж холбогдох зөвлөмжөөр Эрүүл мэндийн байгууллагуудыг ханган ажилласан бөгөөд ЭМЯ-наас ирүүлсэн Эрүүл мэндийн сайдаас Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний эхний хагас жилийн биелэлт, шалгуур үзүүлэлтэд хийсэн үнэлгээ, зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийг 95,8%-тай хангаж ажилласан. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт дунджаар 96.4%-тай байна.		
2	3.2.Зорилтот бүлэгт насны ангиллын дагуу зохион байгуулж байгаа “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо” арга хэмжээнд өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг бүрэн хамруулж, иргэд болон ажил олгогчдыг идэвхжүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэн санаачилгатай ажиллана.	80,0 сая ОНТ	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь	34.1	36.3	Зорилтот бүлэгт насны ангиллын дагуу зохион байгуулж байгаа “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо” арга хэмжээнд харьяа хүн амыг бүрэн хамруулах чиглэлээр үзлэг зохион байгуулах салбар дундын ажлын хэсгийг ЭМГ-ын даргын 2025 оны А/05 тушаалаар байгуулан хурал 12, дэмжлэгт хяналт 10, хяналт үнэлгээ–шинжилгээ 6, идэвхжүүлэх аян 4, эрсдэлт бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг 15 удаа зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын салбар дундын оролцоог ханган төлөвлөгөөний хэрэгжилт 94.6%-тай байна. -Аймгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг 2024 онд 3, 2025 онд 2 лавлагаа шатлалын эмнэлэг нэмэгдэн нийт Эрүүл мэндийн 5 байгууллага хийж байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн байгууллагуудаар аймгийн хэмжээнд нийт 728121 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 283573 хийгдсэн нь нийт үзлэгийн 35.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.2%-иар нэмэгдэж, хүрэх төвшнөөс 1.0%-иар буурсан байна. -Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт Орхон аймгийн 69955 иргэн хамрагдаж, үзлэгийн хамрагдалт 65.9%-д хүрч, улсын хэмжээнд 21 аймгаас хамрагдалтын хувиар тэргүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 05/2192 тоот албан бичиг "Мэдэгдэл хүргүүлэх тухай", Эрүүл мэндийн сайдын 2025 оны өдрийн 1а/4450 дугаар албан бичгээр ирсэн шийдвэрийг үндэслэн дээрх үзлэгийг 2025 оны 10 сарын 01-ны өдрөөс зогсоогоод байна.	54.5

					-Тайлант хугацаанд зонхилон тохиолдох халдварт бус өвчний 5 төрлийн эрт илрүүлэгт 136861 хүн хамруулахаар төлөвлөснөөс 115748 хүн хамрагдаж, хамрагдалтын хувь 84.5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7%-иар буурсан үзүүлэлттэй байна. -Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлага, ажил олгогч нарыг ажилтан албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах чиглэлээр идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлант хугацаанд 122 байгууллагын 15319 ажилтан, албан хаагчийг урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 39.5%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна. - Орхон аймагт ЗГ-ын 2025 оны 42 дугаар тогтоолоор 2025 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Хойд бүсийн ХСҮТ-ийн салбар оношилгооны төв нээгдэж, тайлант хугацаанд 111 иргэнд үзлэг, оношилгоо хийж, бүсийн хэмжээнд хавдрын эрт илрүүлгийн чадавх нэмэгдсэн байна. -Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02/16 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд орон нутгийн төсвөөс 45.0 сая төгрөгийг батлан зорилтот бүлгийн иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулах зорилгоор Засаг даргын А/310, А/779 захирамжийн дагуу төр, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагын оролцоог ханган ХДХВ/ДОХ, тэмбүү, сүрьеэгийн илрүүлэг болон эрүүл мэндийн үзлэгт оюутан залуус, 2025 оны цэрэг татлага, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүчний байгууллагуудын эрэгтэй ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог 12 чиглэлээр зохион байгуулж, нийт 10335 зорилтот бүлгийн хүн ам хамрагдсанаас давхардсан тоогоор 2817 өвчлөл илэрснийг хяналтад авч, эрүүл мэндийн заалтаар 129 хүн цэргийн албанд тэнцээгүй байна. -Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах зорилгоор нийт 5 байгууллагын 847 эрэгтэй ажилтанд урьдчилан сэргийлэх үзлэгийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд болон Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Амурлин тэнгис ТББ-тай хамтран зохион байгуулж, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. -Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03/40 дүгээр тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардлаас 80.0 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгооны арга хэмжээний үйл ажиллагаанд зарцуулсан байна.	
--	--	--	--	--	--	--

3	3.3.Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу харьяалах Эрүүл мэндийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.		Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91.2%	91.3%	Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын дунд хугацааны бодлогын баримт бичиг болох 2025-2028 оны “Стратеги төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийг ЭМГ-ын даргын А/89 дүгээр тушаалаар 8 хүний бүрэлдэхүүнтэй батлаж, нийт 3 удаа хуралдан салбар байгууллагуудын санал авч нэгтгэн стратеги төлөвлөгөөг УЗХ-аар хэлэлцүүлэн тус стратеги төлөвлөгөөг 9 бүлгийн хүрээнд багтааж, байгууллагын тулгамдсан асуудал, статистик тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, нийтлэг салбарт мөрдөгдөх 60 хууль, мандатын шинжилгээнд ерөнхий чиг үүрэг 1, үндсэн чиг үүрэг 6, SWOT шинжилгээнд давуу тал 18, сул тал 15, боломж 7, эрсдэл 6 тодорхойлж, PESTEL анализын аргаар хууль эрх зүйн чиглэлээр 9, нийгэм, эдийн засгийн чиглэлээр 17, гадаад харилцаа, түншлэлээр 11, технологийн чиглэлээр 15 давуу сул талуудыг тогтоон, 12 шалгуур үзүүлэлтийг 4 жилээр хэмжигдэхүйц тоо болон чанарын үзүүлэлтээр гаргаж, 13 зорилтын хүрээнд 47 ажлыг хийхээр төлөвлөн Аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан. -Стратеги төлөвлөгөөнд ЭМГ-ын эрхэм зорилго, зорилтуудыг шинэчлэн гаргасан. 2025 онд тус төлөвлөгөөнд тусгасан 13 зорилтын хүрээнд 47 заалтын хэрэгжилт буюу стратеги төлөвлөгөө 95.6%-тай хэрэгжсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4%, хүрэх түвшнөөс 4.3%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100
4	3.4.Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтаныг хууль журмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана.	-	Сонгон шалгаруулсан удирдах ажилтны тоо	1	3	Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны ил тод байдал, үр ашигтай менежмент хийх удирдлагаар хангах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2024 онд байгуулсан.Тайлант хугацаанд тус зөвлөл нь нийт 4 удаа хуралдсан бөгөөд үүнээс 2 удаагийн хурал цахимаар, 2 удаагийн хурал танхимаар зохион байгуулагдсан. ЭМС-ын 2021 оны А/414 дугаар тушаалын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025 оны 11 сарын 12–28-ны өдрүүдэд Эрүүл мэндийн яам болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй зарыг байршуулсан. Зарлалын дагуу сонгон шалгаруулалтын үйл явцыг зохион байгуулж, шаардлагын дагуу дүнг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд Нийцэл, Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвийн даргыг Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу нөхөрлөлийн гишүүдийн олонхийн саналаар сонгон өрхийн эрүүл мэндийн төвийн даргаар томилогдон ажиллаж байна.	100
5	3.5.Өөрийн харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа	40.5 сая	Төлөвлөгөөний	89.9	90.5	Тайлант хугацаанд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарт 2069 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч	100

	явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангалт, тогтвортой байдалд анхаарлаа хандуулж тэдний нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг дэмжиж ажиллана	ОНТ	хэрэгжилтийн хувь			ажиллаж байна.Эрүүл мэндийн салбарын 2025-2030 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 арга хэмжээ 8 шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 90.5 %-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7%-иар нэмэгдсэн байна. Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS5095:2017,Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS6330:2017 стандартын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөцийн хангалт 91.4%, эмч сувилагчийн харьцаа 1:1.4 байна. Сум,өрхийн эрүүл мэндийн 9 төвд 181 хүн ажиллаж байгаагаас эмч 50, эмнэлгийн мэргэжилтэн 50 ажиллаж, хүний нөөцийн хангалт хүртээмж 100%-тай байна. <i>Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд:</i> Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн 40.5 сая төгрөгийн санхүүжилтээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны сургалтад хамруулсан байна. Солонгос улсын Бусаны Их сургуулийн эмнэлэгт зүрх судас, цээжний хөндийн мэс заслын чиглэлээр 2 эмч, “Эрүүл мэндийн аялал жуулчлалын экспо”-д 1 эмч, Киргизстан улсын Бишкек хотноо зохион байгуулагдсан “Хөнгөвчлөх эмчилгээний олон улсын удирдлагын сургалтад 1 эмч, АНУ-ын Харвардын сургалтын хөтөлбөрт 1 эмчийг тус тус оролцуулж, орон нутгаас 8 сая төгрөгний санхүүжилтийг олгож дэмжлэг үзүүлсэн байна. Төрөлжсөн болон мэргэшүүлэх сургалт, нийгэмлэгийн хуралд давтагдсан тоогоор 1956 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаж ур чадвараа нэмэгдүүлсэн. Төрийн болон Эрүүл мэндийн яам, орон нутгийн шагналд 149, Сувилахуйн нийгэмлэг, Монголын залуучуудын холбоо, Үйлдвэрчний эвлэлийн шагнал 27 нийт 176 эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилчдыг шагнаж урамшуулан 12 эмнэлгийн ажилтнууд 5.0 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнагдсан байна. -ЭМЯ-наас зохион байгуулсан Эрүүл мэндийн байгууллагуудын 5 төрлийн спортын тэмцээнд амжилттай оролцсон 2 мэргэжилтэнд тус бүр 150,0 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Жаргалант сумын ЭМТ-ийн 2 их эмчийг орон сууцаар хангаж, орон сууцны урьдчилгаа 30%-ийг Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн жолоочид, олон жил ажилласан 1 ажилтанд 13.8 сая, Талын	
--	---	-----	-------------------	--	--	--	--

						булаг эмнэлэг 2 ажилтандаа тус бүр 10 сая, Эрдэнэт Медикал 3 ажилтанд тус бүр 13 сая, Ачит” эмнэлэг 20.4 сая төгрөгийг байгууллагаас олгосон байна. Мөн ажилтны ар гэрийн гишүүдийн эрүүл мэнд болон хүүхдийн сургалтын төлбөр бусад урамшуулалд нийт 25,200,000 төгрөгний дэмжлэг үзүүлж, гадаад улс руу аялах эрхийн бичгээр Эрдэнэт “Медикал” эмнэлэг 3, Очир Увидас эмнэлэг 13 эмч, эмнэлгийн ажилтнуудыг тус тус шагнаж урамшуулсан байна. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эрүүл мэндийн салбар байгууллагуудын 78.4% буюу 1639 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан, 13.7 сая төгрөгийн амин дэмжүүлэлтэд хамруулан дэмжлэг үзүүлсэн байна.	
6	3.6.Эрүүл мэндийн байгууллагын барилгыг шинээр ашиглалтад оруулсан тохиолдолд хуучин барилгыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглахгүй байх, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18, 21.1.16 дахь заалтын дагуу төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээний ажлын санхүүжилтийг бүрэн шийдвэрлэн ажиллана.	1.1 тэрбум ОНТ	Хэрэгжил тийн хувь	100%	100%	2025 онд орон нутгийн 3.5 тэрбум төгрөгийн төсвөөр Оюут багт төрийн үйлчилгээний нэгдсэн төв баригдаж ашиглалтад орсон. Ингэснээр 2, 2а хорооллын 10000 гаруй хүн амд үйлчлэх 1100 м2 талбай бүхий өрхийн эмнэлгийн байртай болж, Оюут багийн хүн амд үйлчлэх хүрээ ойртсон байна. Энхжихмандариваа, Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвүүд 2024 онд шинэ байранд орж үйл ажиллагаагаа явуулж байгаа тул тус төвүүдийн хуучин барилгуудыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглаагүй бөгөөд аймгийн Өмчийн газарт хүлээлгэн өгөөд байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хавдрын оношилгоо эмчилгээний төвийн их засварт 350.0 сая, гемодиализын тусламж үйлчилгээ үзүүлэх хэсгийн их засвар 543.0 сая, мэс заслын тасгийн дээврийн засварт 89.9, Дэнж багт байрлах Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төвийн гадна фасад, дээврийн засварт 160.0 сая төгрөг нийт орон нутгийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дээрх засвар үйлчилгээ 100 хувь хийгдэж, ашиглалтад орсон байна.	100
7	3.7.Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор үүссэн өр, авлагыг барагдуулан шинээр өр үүсгэхгүй санхүүгийн сахилга баттай ажиллах.		Өр авлага үүсээгүй байна	4.3 тэрбум	8.4 тэрбум төгрөг	Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн салбар байгууллагын хувьд 2024 оны жилийн эцэст нийт 4.3 тэрбум төгрөгийн өр төлбөр байснаас ажилтан, албан хаагчидтай холбоотой 332.2 сая төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн өр төлбөр 2.8 тэрбум, бараа ажил үйлчилгээний бусад өглөг, байгууллагад төлөх өглөг нийт 425.5 сая төгрөг байгаа ба 2025 онд 2.8 тэрбумын авлагыг бууруулж, 28.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Өр төлбөрийн хувьд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2025 оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал нийт өр төлбөр 2 дахин буюу 4.1 тэрбум төгрөгөөр өсөж нийт өр 8.4 тэрбум төгрөг байна. Нийт өр төлбөрийг бүтцээр нь задалбал:	0

						-Ажилчин, албан хаагчидтай холбоотой өр төлбөр 2.6 тэрбум буюу оны эхнээс 7.8 дахин их -Эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөр өмнөх оноос үлдэгдлээс 1.5 тэрбум 60.7%-иар өссөн -Бусад бараа ажил үйлчилгээ, байгууллагад төлөх өглөг өмнөх оноос 0.9 тэрбум буюу 3.3 дахин тус тус өссөн байна. Үүссэн нийт өр төлбөрийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт улсын хэмжээнд тасарснаас шалтгаалан өр төлбөр хуримтлагдаж үүсээд байна.	
8	3.8.Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн суралцагчдын амрагдалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулна.		Эрүүл мэндийн даатгалын хамралт	90.2%	91%	ЭМДХ-тэй хамтран эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулж, 18 байгууллагын 1467 хүнийг хамруулж, эрүүл мэндийн даатгалын хамралт 91 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,8%-иар нэмэгдсэн байна. -Тайлант хугацаанд 4 удаагийн нээлттэй хаалганы өдрөөр 1384 хүн, цэрэг татлагаар 1241 залуучуудыг сургалт сурталчилгаанд хамруулснаас 50 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан. Жаргалант суманд зохион байгуулсан малчид, тариаланчдын өдрөөр 106 хүнийг сургалтад хамруулан 30 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан байна. -Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 110 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан. Үүнээс эрүүл мэндийн даатгалгүй зорилтот бүлгийн 116 хүний 82.0%-ийг үзлэг шинжилгээнд хамруулсан. -Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагууд явуулын, түр оршин суугч 4570 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй шуурхай үзүүлсэн байна. -Эрүүл мэндийн даатгалгүй, зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь 95% байна.	100
9	3.9. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмчийн харьяаллыг өөрчлөх, төрийн өмчит	-	Шинээр байгуулагдсан ЭМБ-ын тоо	0	1	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 42 дүгээр тогтоолоор Эрдэнэт Медикал эмнэлгийг Хавдар Судлалын Үндэсний төвийн харьяа Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв болгосон.Ингэснээр Хойд бүсийн хэмжээнд хавдрын төрөлжсөн тусламж үйлчилгээг үе шаттай үзүүлэхээр 2026-2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө батлагдан, 98 ортой эмнэлгийн зураг төсөв	100

	байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд Захиалагч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.					хийгдээд байна. Орхон аймгийн хүн ам 106,000-д хүрч, засаг захиргааны нэгж болох багийн тоо 3-аар нэмэгдэж, нийт 29 багтай болсонтой уялдуулан анхан шатлалын тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор анхан шатны тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ, хүртээмжид үнэлгээ хийн одоо байгаа Өрхийн эрүүл мэндийн 8 төв дээр нэмж шинээр 2 өрхийн эрүүл мэндийн төв байгуулах үндэслэл, саналыг Засаг даргын зөвлөл, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн тус хурлын 2025 оны 10-р сарын 1-ний өдрийн 03/47 дугаар тогтоолоор Уртбулаг, Бүрэнбүст баг болон Оюут баг, 2а хороололд шинээр байгуулагдах 2 өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээ, хүн амын тоог батлуулсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд өрхийн эрүүл мэндийн 1 төв байгуулах сонгон шалгаруулалтыг холбогдох журмын дагуу 2026 онд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
3.10.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:							
10	3.10.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулна.		Зохион байгуулсан ажлын тоо	6	37	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг 37 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 14374 хүнд сурталчлан 72 удаагийн уулзалт ярилцлага, сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн төв, сургууль цэцэрлэг, албан байгууллагын эмч, эрүүл ахуйч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан зэрэг давхардсан тоогоор 3114 хүнийг хамруулан хуулийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/84 дүгээр захирамжийн дагуу Эрүүл мэндийн газрын бүтцэд байгаа Нийгмийн эрүүл мэндийн төвд 5 мэргэжилтэн орон тоогоор ажиллаж, нийт хүн амд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангах чиглэлээр салбар дундын хэлэлцүүлэг 2, хурал 12, сургалт 25, нээлттэй хаалганы өдөр 7 удаа зохион байгуулж, Эрүүл мэндийн байгууллагуудад удирдлага, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн, салбар дундын оролцоог хангаж ажилласан. Анхан шатлалд нийгмийн эрүүл мэндийн 9 ажилтан орон тоогоор дагнан ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5-аар нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан байна. Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн магистрт 1, Талбарын тархвар судлалын анхан шатны сургалтад 1 мэргэжилтэн, 70 удаагийн зайн болон танхимын сургалтад давхардсан тоогоор 46	100

						нийгмийн ажилтанг хамруулан чадавхжуулсан байна.	
11	3.10.2.Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулна	110.0 ОНТ	Зохион байгуулсан ажлын тоо	12	44	Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр АЗДТГ, БГ, ХГБХГ, ЦГ, ОБГ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Төрийн бус 10 байгууллагатай хамтран салбар дундын оролцоог ханган 165 аж ахуйн нэгж байгууллага болон 24788 иргэнийг 44 удаагийн нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан байна. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 12 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Аймгийн хэмжээнд “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд орон нутгийн 110.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд эрүүл мэндийн салбар байгууллагуудаас зохион байгуулсан 23 удаагийн сургалт, үзлэг, өдөрлөг, нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. Шүдний мэргэжилтний холбоотой хамтран амны хөндийн эрүүл мэндийг сахих, зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, 22500 гаруй багш, хүүхдийг хамруулсан байна.Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” шүд, гараа зөв угааж сурах аяныг өрнүүлж, эцсийн үр дүнг эцэг эх асран хамгаалагч нар хүүхдийнхээ шүд болон гарыг хэрхэн угаах уралдаанаар дүгнэж үнэллээ.Уг арга хэмжээ улсын хэмжээнд анх удаа зохион байгуулагдаж, 248 хүүхэд 248 эцэг эх асран хамгаалагч 64 багш, зохион байгуулагчаар 10 мэргэжилтэн, уралдааны шүүгчээр Орхон аймгийн шүдний мэргэжилтний холбооны 40 мэргэжилтэн, өрхийн эрүүл мэндийн төвийн 8 мэргэжилтэн нийт 630 хүний оролцоотой зохион байгуулагдлаа. Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг өрнүүлж 24 сургуулийн 25122 хүүхдийг хамруулсан байна.	100
12	3.10.3.Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа “Эрүүл Монгол хүн”, “Халдварт өвчнөөс	45.0 ОНТ	Төлөвлөгөөний дундаж хэрэгжил	88.1%	90.0%	“Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд 2025 онд 16 ажлыг хийхээр төлөвлөгөөг батлуулж 87.5%-тай хэрэгжсэн. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих боловсрол олгох чиглэлээр орон нутгийн 8.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулсан 15 төрлийн сургалтад 54 төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, цэцэрлэг,	100

	сэргийлэх, хянах”, “Эрүүл шүд”, “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх”, “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээ гэх мэт хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.		т			ерөнхий боловсролын сургуулийн нийт 55929 хүнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар нэмэгдсэн байна. Боловсролын байгууллагын 56 нэгж, сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” аян улсын хэмжээнд анх удаа зохион байгуулагдаж, 248 хүүхэд 248 эцэг эх асран хамгаалагч 64 багшийг оролцууллаа. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нүүр амны эрүүл ахуйч сургагч багшаар бэлтгэх, онол гардан үйлдлийг хослуулсан сургалтыг Аймгийн ЗДТГ, ИТХ, Мишээл хүүхэд сан ТББ, Эрүүл мэндийн газар, Шүд холбоотой хамтран 85 сургууль, цэцэрлэгийн эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төв эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, шүдний эмч, эрүүл ахуйч нарыг хамруулж багц хэрэглэгдэхүүн 85 ширхгийг бэлтгэн тарааж, гэрчилгээг гардуулан өгсөн. “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” зорилгоор 2025 онд 31 удаагийн өдөрлөг, аян, форум, 276 удаагийн сургалт сурталчилгаанд 165 байгууллагын давхардсан тоогоор 110373 иргэнийг хамруулж, 55 төрлийн сурталчилгааны материалыг 9471 иргэнд түгээн, цахим хуудаст 1250 төрлийн гарын авлага, шторка, видео болон постер зөвлөмжийг байршуулан 26242 хандалт авсан байна. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээний хэрэгжилт 93.5%-тай байна. Тайлант хугацаанд 971 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 91.3 промилл ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 202 тохиолдлоор нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн сайдын 4, Засаг даргын 2 албан даалгаврын хэрэгжилт дундажаар 92,1%-тай хэрэгжсэн байна. Томуу,томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн 4 удаагийн хурлаар 9 асуудал хэлэлцэж, шийдвэрийн хэрэгжилт 95.6%-тай хангагдсан байна. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудад 5 удаа,хүүхдийн байгууллагуудад 4 удаа дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч хэрэгжилт 94,2%-тай байна. Арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн газрын даргын 10 тушаал, 7 төлөвлөгөө, 15 удирдамжийг батлуулан хэрэгжилтийг 95.7%-тай ханган ажилласан. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаагийн өдөрлөг, 4 аян, 256 удаагийн сургалт зохион байгуулж нийт 1600 гаруй иргэнийг хамруулсан. Хэвлэл мэдээллээр 17 удаа мэдээлэл өгч, цахимаар 42 мэдээлэл түгээж 65000 хүнд хүргэсэн. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 61 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж хэрэгжилт 89,7 %-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5,9%-иар	
--	--	--	---	--	--	---	--

						нэмэгдсэн байна. “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх чиглэлээр 38 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан 12 удаагийн өдөрлөгт 6100 хүүхэд, өсвөр үе, насанд хүрэгчдэд зөвлөмж зөвлөгөө мэдээлэл хүргэж, 48 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд төрийн байгууллагын албан хаагчид болон үйлдвэрийн ажилчид, 16-49 насны эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ерөнхий боловсролын сурагчид нийт 31245 хүнийг хамруулан 18 төрлийн гарын авлага, зөвлөмжийг давхардсан тоогоор 42080 иргэнд түгээж мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар давхардсан тоогоор 486 мэдээлэл оруулснаар хандалтын тоо 107262-т хүрсэн байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн хөгжлийн хороо, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран архины хэрэглээний эмгэгтэй хүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэтгэц-нийгмийн сэргээн засах төв”, “Аддиктологийн төв”-ийн үйл ажиллагаатай 10 хүний бүрэлдэхүүнтэй туршлага судалсан байна. Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 93.6%-тай хэрэгжсэн байна. “Эрүүл Монгол” хөтөлбөрийн хүрээнд элэгний В вирусийн оношлуур 6726, С вирусийн оношлуур 6693 хүнд тавьсан бөгөөд элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн 40-65 насны 1993 (107.3%) хүн хамрагдсан. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг идэвхжүүлэх чиглэлээр салбар дундын хурал 6 удаа, дэмжлэгт хяналт 4 удаа, зөвлөмж 2-оор ханган ажилласнаар Эрүүл Монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилт 85.5%-тай байна. Дээрх 4 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 90.0%-тай байна.	
13	3.10.4. 'Нас, хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг •Ургийн гажгийн эрт илрүүлэг, •Нярайн эрт илрүүлэг, •Сургуульд суурилсан эрт илрүүлэг,	390.0 сая ОНТ	Эрт илрүүлгийн дундаж хувь	89.5%	84.5%	Тайлант хугацаанд зонхилон тохиолдох халдварт бус өвчний 5 төрлийн эрт илрүүлэгт 136861 хүн хамруулахаар төлөвлөснөөс 115748 хүн хамрагдаж, хамрагдалтын хувь 84.5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7%-иар буурсан. Үүнд: - 2025 онд артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 63414 хүн хамруулахаар төлөвлөснөөс 55755 /87.9%/ хүн хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 10.3%, буурч, хүрэх түвшнөөс 12.8%-иар нэмэгдсэн байна.. -Тайлант хугацаанд чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 35-аас дээш насны 41471 буюу хамрагдвал зохих хүн амын	100

	•Ажлын байран дахь эрт илрүүлэг -Хавдрын эрт илрүүлэхийг өөрийн орон нутагт зохион байгуулахад манлайлан ажиллах харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг бүрэн хамруулна					100.0 хувь хамрагдсан нь өмнөх оноос (13.3) хувиар нэмэгдэж, 0.4 %-д онош батлагдсан байна. 2025 онд умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 5764 эмэгтэйг хамруулахаар төлөвлөснөөс 3487 /60.5%/ эмэгтэй хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 34.4%-иар буурч,хүрэх түвшнөөс 18.2%-иар нэмэгдсэн байна. Нийт 2913 шинжилгээнээс 2627 буюу 90.1 хувь нь хэвийн гарсан байна. Тайлант хугацаанд 30-60 насны 24454 эмэгтэйг хөхний эрт илрүүлэг үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 21622 хүн буюу 88.4% хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 1302, хүрэх түвшнөөс 3996 хүн илүү хамруулсан байна. -Аймгийн хэмжээнд пренатологич 2 эмч ургийн гажгийн үзлэг илрүүлэх 1357 үзлэг хийж, өвчний учир 928, идэвхтэй хяналтад 429 эх бүртгэгдсэн. Жирэмсний эрт үеийн нийлмэл илрүүлэгт 141 эхийг хамруулж, эрсдэлтэй 20 эхээс 13 NIPT, 5 ургийн усны шинжилгээ хийж,эрхтэн тогтолцооны гажигтай 2 жирэмслэлтийг эрт хугацаанд нь шийдвэрлэсэн байна.Ургийн бүтцийн ЭХО-д давхардсан 270 гаруй эмэгтэй хамрагдаж, олон урагтай 18, дээд шатлалд 7 эмэгтэйг илгээж, RH-сөрөг жирэмсэн 2, төрөл бүрийн ургийн гажигтай 11 тохиолдлыг оношлон 3-р шатлалд илгээж, жирэмслэлт тээлтийг шийдүүлсэн. -Төрсөн 1610 нярайг нярайн тандалт скрининг шинжилгээнд 100% хамруулснаас түнхний үений эхо оношилгоонд 1605 /99.6%/, сонсголын скрининг 1111, нүдний угийн улаан рефлекс 1605,бодисын солилцооны 5 төрлийн эмгэг илрүүлэх оношилгоонд 1180 нярайг хамруулсан байна. 2025 оны 10 сараас шинээр пульсоксиметрийн скринингийг орон нутагт нэвтрүүлэн, 165 нярайг хамруулснаас зүрхний эмгэг өөрлөлттэй хүүхэд илрээгүй байна. Бодисын солилцооны скринингт 1180 нярайг хамруулж, өөрчлөлттэй илэрсэн 1 нярайг хяналтад авсан. -Сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2554 буюу 99.1 хувь нь хамрагдаж, 1773 буюу 68.8 хувьд өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрч, 720 буюу 28.1 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. Үүнд: -Шүдний илрүүлэгт 2433 хүүхэд хамрагдахаас 94.4% нь хамрагдсан.Үзлэгээр 2405 /99%/ хүүхэд фторт түрхлэг түрхүүлсэн, шүдний цооролтой 1991 /81.8%/, шүдний гажигтай 673 /27,6%/, шүдээ бүрэн угаадаггүй 1974 /81.1%/, шүдний эмчилгээнд хамрагдсан 720 / 48.4%/ хүүхэд байна. Нүдний илрүүлэгт 2425 хүүхэд хамрагдахаас 94,1% нь хамрагдаж, 579 буюу 23,8 % нь харааны өөрчлөлттэй гарч, холын хараа	
--	---	--	--	--	--	---	--

						тэнцээгүй 289 /11.9%/, ойрын хараа тэнцээгүй 84 /3.4%/, стерео хараа тэнцээгүй 206 /8.5%/ илэрснийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад авсан байна. Зүрхний эмгэг илрүүлэг үзлэгт 2393 хүүхэд хамрагдахаас 92.9%-ыг хамруулж, үүнээс зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлттэй илэрсэн 363/ 15,1%/ хүүхдээс 315 буюу 86,7%-ийг зүрхний эхо оношилгоонд хамруулан 27 хүүхдэд зүрхний эмгэг илэрч, хяналтад авсан байна. -Анхан шатлалд сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв хавдрын маркерийг 8956 хүнд хийж, эерэг илэрсэн 16 тохиолдлыг лавлагаа шатлалд илгээсэн байна. -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төвд нийт 5083 иргэн хавдрын эрт илрүүлэгт хамрагдсанаас шинээр 147 хавдар илэрч, идэвхтэй хяналтад орсон байна. -Засгийн газрын 2025 оны 42 дүгээр тогтоолоор Эрдэнэт Медикал эмнэлгийг Хавдар Судлалын Үндэсний төвийн харьяа Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв болгосноор мэргэжлийн 3 эмч ажиллан 111 иргэнд үзлэг хийж бүсийн хэмжээнд хавдрын эрт илрүүлгийн чадавх нэмэгдсэн. -Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 296 шинэ хорт хавдрын тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 27.6 промилл байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 тохиолдол буюу 0.9 промиллээр нэмэгдсэн байна. -Хорт хавдартай иргэдэд дэмжлэг үзүүлэх аймгийн зөвлөлд өргөдөл ирүүлсэн 185 иргэний эмийн зардалд 102.2 сая төгрөгийн дэмжлэгийг зөвлөлийн хурлын шийдвэрээр үзүүлсэн байна.	
14	3.10.5.Алслагдсан сумдад амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо, эмчилгээний Явуулын баг ажиллуулан урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг санхүүжилтийн хувьд дэмжлэг үзүүлэн ажиллана.	15,0 ОНТ 51,0 УТ	Зохион байгуулсан үзлэгийн тоо	1	4	Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медициналь төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрдэнэт клиник болон хувийн хэвшлийн 13 шүдний клиникт 120 эмч, эмнэлгийн мэргэжилтэн шүдний тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаагаас 61 буюу 50.8% нь их эмч ажиллаж байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газар, сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв, шүдний 13 клиниктэй гэрээ байгуулан сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх шүдний илрүүлэг хийх явуулын үзлэгт 29 багийн 22 сургуулийн 2433 хүүхдээс 94.4%-ийг хамруулсан. Үзлэгээр 2405 хүүхдэд фторт түрхлэг түрхэж, шүдний цооролтой 1991, шүдний гажигтай 673, шүдээ бүрэн угаадаггүй 1974, шүдний эмчилгээнд хамрагдсан 707 хүүхэд байна. Алслагдсан сум болох Жаргалант сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн 51.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шүдний кабинет байгуулан, Хаш шүдний эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний	100

						дагуу Жаргалант сумын 3-р сургуулийн 1 дүгээр ангийн 35 хүүхдийг шүдний үзлэг, фторт түрхлэгт хамруулан 30 хүүхдэд шүдний эмчилгээ, 7 хүүхдэд гажиг заслын эмчилгээ, 14 хүүхдэд мэс заслын эмчилгээ шаардлагатай нь илэрсэн байна. Мөн нийт 29 хүүхдэд шүдний силант түрхлэг түрхэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан. Тайлант хугацаанд Шүдний мэргэжилтний холбоо, Шүдний 5 эмнэлэгтэй хамтран малчдын үзлэгт 152 хүн, цэргийн насны 178 залуучууд, цагаан тоосны нөлөөллийн бүсийн 1500 нийт 1678 хүнд явуулаар амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийж, шүд угаах аргачлалыг таниулах сургалт нөлөөллийг ажлыг зохион байгуулсан. Аймгийн ХХААГ болон сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран Жаргалант сумын Дулаан-Уул багийн малчдын эргэлтийг 2 удаа хийж, 298 өрхийн 452 иргэнийг хамруулан эмчийн үзлэг, зөвлөгөө өгч, явуулын эмийн сангаар үйлчилсэн. Мөн орон нутгийн 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар давхардсан тоогоор 1262 иргэнд 10 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээ нэн шаардлагатай 32 хүнийг лавлагаа шатлалд шилжүүлсэн байна.	
15	3.10.6.Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, тэр дундаа Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц МонПЭН болон мобайл технологи ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллана.	133.5 Сая ОНТ	Тоног төхөөрөм жийн хангалты н хувь	95.5%	95.6%	2024 онд орон нутгийн төсвөөр өрхийн эрүүл мэндийн 3 төв, 2025 онд орон нутгийн 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өрхийн эрүүл мэндийн 1 төвд мобайл технологийг нэвтрүүлснээр Орхон аймгийн анхан шатны эрүүл мэндийн 7 байгууллага буюу 77.7%-д мобайл технологийн хангалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11.1%-иар нэмэгдэж, тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь 95.6%-д хүрсэн байна. Мобайл технологийн зөөврийн эхо, зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийг гэрийн эргэлт болон урьдчилан сэргийлэх үзлэгүүдэд ашиглаж байна. Мобайл технологиор 2025 онд 2360 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.Үүнд:Эхо-204, ЭКГ-2156 хүнд хэвтрийн,байнгын асаргаа шаардлагатай 51 ахмадад давхардсан тоогоор 204 удаа зөөврийн эхо оношилгоо хийсэн.Зөөврийн ЭКГ-ээр 2156 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс ахмад-291 (13.5%), ХБИ-35 (1.6%), залуучууд-1830 (84.8%) байна. МОНПЭН санаачлагын хүрээнд 2025 оны 9 дүгээр сард удирдлагын түвшний уулзалтыг зохион байгуулж, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, АШИУС, Булган аймгийн Засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн газраас төлөөлөгчид оролцон чадавхийг бэхжүүлэх хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 23 эмч,эмнэлгийн мэргэжилтнүүдийг 3 өдрийн сургалтад хамруулан чадавхжуулсан. Тус төслийн хүрээнд ДЭМБ–	100

						ын Зүрх судасны өвчний цогц менежментийг өрхийн эрүүл мэндийн 8 төв, сумын эрүүл мэндийн төвд нэвтрүүлж, зүрх судасны өвчин болон чихрийн шижингийн эрт илрүүлгийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулсан.Үүнд: -Артерийн даралт ихсэлтийн илрүүлэгт 4,707 хүн хамрагдаж, 16 шинэ тохиолдол илрэн онош батлагдаж, хяналтад авсан. -Чихрийн шижингийн илрүүлэгт 4,241 хүн хамрагдаж, 13 шинэ тохиолдлын онош батлагдан, лавлагаа шатлалын эмчийн хяналтад авсан байна.	
16	3.10.7.Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах,урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, авто тээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	5.0 ОНТ	Нөлөөллийн арга хэмжээний тоо	2	3	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд сэтгэцийн өвчлөлийн 1371 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 128.9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.3 промиллоор буурсан байна. -Сэтгэц нөлөөт эмийн бодисын шалтгаант сэтгэцийн аягийн эмгэг 498 бүртгэгдэж 10 000 хүн амд 46.8 промил өмнөх оны мөн үеэс 2.0 промилоор буурч, архины шалтгаант болон зан төрхийн эмгэг шалтгаант өвчлөлөөр 416 хүн хэвтэн эмчлүүлсэн ба 10 000 хүн амд 39.1 промил өмнөх оны мөн үеэс 0.2 промилоор өссөн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд сэтгэцийн эмч 2, хувийн хэвшил сэтгэцийн оргүй клиник 1, ортой клиник 1, Эрдэнэт клиникт сэтгэцийн эмч 1, Ерөнхий боловсролын 23 сургууль байгаагаас 16 сургуульд сэтгэл зүйч ажиллаж хүүхэд, өсвөр үе, зорилтот бүлгийн хүн амд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн Засаг даргын тамхины хяналтын тухай хуулийн болон утаат, электрон тамхи худалдан борлуулах, хэрэглэхийг хориглож хязгаарласан захиргааны акт, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулах аян, сургалт нөлөөлөл, хяналт шалгалт хийх нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу 4 байгууллага хамтран зохион байгуулсан 5 удаагийн арга хэмжээ, 35 удаагийн сургалтад 20 ЕБСургууль, Орхон МСҮТ-ийн оюутан, сурагч нийт 10100 хүн, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын цехүүдийн ажилчдад “Өглөөний ХАБ”-аар мэдээллийг давхардсан тоогоор 6500 ажилтанд түгээж, тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулдаг 57 нэрийн дэлгүүрүүдээр хяналт хийж,16 төрлийн 2408 тараах материал тарааж ажилласан. “Архи, тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх нь” сургалтад цэрэг цагдаагийн байгууллагын албан хаагчид болон үйлдвэрийн ажилчид нийт 1030 хүн хамрагдсан. Эрүүл мэндийн салбарын 10 пэйж хуудсаар өдөр бүр мэдээлэл оруулж иргэдэд түгээн ажилласан ба нийт давхардсан тоогоор 371 мэдээлэл оруулж, хандалтын тоо 56841 байна. “Дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдөр”-ийг төрийн болон төрийн бус 16 байгууллагатай хамтран “Сэтгэцийн эрүүл мэндийн өдөрлөг”-	100

					ийг Соёл урлагийн цогцолборт зохион байгуулж,сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын 11 өртөө ажиллан, 247 иргэнд сэтгэл зүйн чиглэлийн мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгч, оношилгоо хийн давхардсан тоогоор 1800 хүнд сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгосон байна. “Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе” аяны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 18 үйл ажиллагааг 10 байгууллагатай хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 94.4 хувьтай хэрэгжиж, салбар дундын хэлэлцүүлэг 2 удаа хийсэн байна. Аймгийн хэмжээнд “Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж-эрсдэлийг бууруулъя”уриатай иргэдэд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөмжийг цаг алдалгүй хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 5 төрлийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилт 95 хувьтай байна. Орхон аймгийн эрүүл мэндийн газрын цахим хуудас 9 өрхийн эрүүл мэндийн цахим хуудсаар 8 зурган мэдээлэл, 10 видео шторкийг бэлтгэж иргэд олон нийтэд түгээн ажиллалаа.Тус мэдээллийг нийт давхардсан тоогоор 12179 иргэн үзэж танилцсан байна. Цагдаагийн газартай хамтран анхан шатны эрүүл мэндийн байгууллага болон сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургуулийн нийт 45 байгууллагын 58 эмч, эмнэлгийн ажилтнуудад 6 сэдвийн хүрээнд сургалт орж чадавхжуулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал, Улаан загалмайн хороотой хамтран анхан шатны эрүүл мэндийн байгууллага,хүүхдийн 45 байгууллагын 58 эмч, эмнэлгийн ажилтнуудад осол гэмтлийг бууруулах, арга хэмжээ авах чиглэлээр 6 сэдвээр сургалтад хамруулан чадавхжуулж,дээрх сургагч багш нар харьяаллын дагуу 15 сургуулийн 2412 хүүхдэд осол гэмтлээс сэргийлэх сургалт нөлөөллийг ажлаар эрүүл мэндийн боловсрол олгож, 5 төрлийн гарын авлага түгээн ажилласан. Баян-Өндөр сумын 25 багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй 530 ААН 19555м2 явган зам, 5372м2 авто зам, 25090 м2 бусад талбай нийт 47917,274 м2 талбайн цас цэвэрлэгээг зохион байгуулж халтиргаа, гулгаанаас сэргийлэх арга хэмжээг авч ажилласан. Тайлант хугацаанд зам тээврийн ослын 214 тохиолдол буюу 22,9% бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4,2%-аар өссөн дүнтэй байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралт 51 бүртгэгдсэнээс зам тээврийн ослын шалтгаант нас баралт 9 бүртгэгдэж,10.000 хүн амд 0.8 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 7 тохиолдол буюу 0.6 промиллээр өссөн байна. Тайлант хугацаанд осол гэмтлийн өвчлөлийн 969 тохиолдол бүртгэгдэж, 10.000 хүн амд 91.1 промилл	
--	--	--	--	--	--	--

						байгаа нь өмнөх оны мөн үеэс 475 тохиолдол буюу 46.1 промиллоор буурсан байна.	
17	3.10.8.Хүн амын дунд зонхилон тохиолдол байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнд улирал бүр хянана	11,9 ОНТ	Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь	23.8	22.5	-Сүрьеэ,бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн сайд, Засаг дарга болон бүх шатны засаг дарга, эрүүл мэндийн салбарын дарга нарын гэрээнд тусган, үр дүнг тооцож мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн салбар дундын оролцоог хангаж ажилласан. -Тайлант хугацаанд 971 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 91.3 промилл ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 202 тохиолдлоор нэмэгдсэн байна. Нийт халдварт өвчний бүтцэд 37.2% нь амьсгалын зам, 18.7% нь бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 6.5% нь гэдэсний халдвар, 37.2 промиллийг бусад халдварт өвчин эзлэж байна. -Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн удирдамж батлуулан салбаруудад хүргүүлэн биелэлтийг 88.5%-тай ханган ажилласан. Сум,өрхийн эрүүл мэндийн төвүүд эрсдэлт бүлгийн 3790 хүний судалгааг гаргаж, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 7 байгууллагад нийт 25 удаагийн идэвхтэй илрүүлэг үзлэг шинжилгээг явуулаар хийж, 1872 хүнийг хамруулан, 198 хүнд сорил, 15 хүнийг цэрний шинжилгээнд хамруулсан. Сорил эерэг гарсан 34 хүнийг урьдчилан сэргийлэх, 1 тохиолдлыг эмэнд мэдрэг сүрьеэгийн эмийн эмчилгээнд хамруулсан. Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь 63.6% байна. -Цэрэг татлагын 2 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэгт 499 залуусыг хамруулж, БЗДХ-ын 4, сүрьеэгийн сэжигтэй 8 тохиолдлыг илрүүлж бүртгэл, хяналтад авсан. Сүрьеэ болон ДОХ-той тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд Улаан загалмайн хороо, Боловсролын газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтран 17 арга хэмжээг зохион байгуулж, 1375 хүнийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. -Тайлант хугацаанд орон нутгийн 11, сая төгрөгийн санхүүжилтээр сүрьеэ, БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэгт 1118, эрэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 300, цэрэг татлагаар 499, хорих ангийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 102, 12 аж ахуйн нэгж байгууллага, МСҮТ, их дээд сургуулийн эрэгтэйчүүдийн дунд хийгдсэн идэвхтэй эрт илрүүлэг үзлэг, тандалтаар нийт 4000 хүнд ДОХ/Тэмбүүг илрүүлэх түргэвчилсэн сорилоор оношилгоо хийж,	100
			Нийт халдварт өвчинд эзлэх БЗДХ-ын эзлэх хувь	19.6	18.7		

						БЗДХӨ-өөс сэргийлэх сургалт сурталчилгаанд хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. -Шинээр хяналтад хамрагдсан 1579 жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 33 буюу 2.0 хувь, тэмбүү 11 буюу 0.7 хувь, заг хүйтэн 1 буюу 0.07 хувь тус тус эерэг гарч,хавьтлын хамт эмчилгээ хяналтад авсан бөгөөд төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдол бүртгэгдсэн байна. Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, хүний папилома вирусын халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтад Боловсролын газар, сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, Амурлин тэнгис ТББ-уудтай хамтран 3 арга хэмжээг зохион байгуулж, 4750 сурагч, 2700 гаруй эцэг эх, асран хамгаалагч нарын төлөөллийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. -Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг “Асуудлыг шийдье, ДОХ-ын эсрэг хариу арга хэмжээг сайжруулъя” уриан дор ЭМГ, БОЭТ, “Амурлин тэнгис” ТББ-тай хамтран “БЗДХ/ХДХВ/ДОХ гэж юу вэ?”, “Өсвөр үеийн сэтгэлзүйн онцлог ба сэтгэцийн эрүүл мэнд”,“БЗДХ-аас сэргийлэх арга замууд” сэдэвт сургалтад 1450 оюутан, сурагчдыг хамруулан танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж, сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэн мэдлэгийг бататгасан.“Улаан тууз”сэдвээр ЕБС-ын сурагчдын дунд богино бичлэгийн уралдаан зарлаж, 150 гаруй хүүхдүүд хамрагдсан байна.Эрүүл мэндийн 9 салбарын цахим хуудаст 2 төрлийн зурган зурагт хуудас байршуулж нийт 1417 хүнд хүргэсэн. -2025 онд сүрьеэ өвчний 80 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 7.5 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 23 тохиолдол буюу 2.3 промиллоор буурч, хүрэх түвшнөөс 0.9 промиллээр өссөн дүнтэй байна. Бэлгийн замаар дамжих халдварын 182 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 17.1 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.8 промиллоор өсөж, нийт халдварт өвчинд бэлгийн замын халдварт өвчний эзлэх хувь 18,7% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,9%-иар буурсан байна.	
18	3.10.9.Дархлаажуулалтын хамралтыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлнэ	23,7 сая ОНТ	Дархлаа жуулалтын хамралтын хувь	99,8	99,7	Товлолын дархлаажуулалтад хамрагдвал зохих 12969 хүүхдээс 12932 хүүхэд хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 99,7% буюу өмнөх оны мөн үеэс 0.1%-иар буурсан байна. Дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, халдварт өвчний хариу арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр Засаг даргын захирамжаар 2 ажлын хэсэг байгуулж, орон нутгийн 23,7 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, хэрэгжилтийг 100% хангаж ажиллалаа. Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад 745 хүүхдийг хамруулан,1774 хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд нөхөж	100

						оруулсан байна. -Дархлаажуулалтын талаар иргэдэд мэдээлэл түгээх 4 удаагийн аян, 2 өдөрлөг зохион байгуулж, 1 төсөл хэрэгжүүлэн ажилласан. Дээрх арга хэмжээнд 70 гаруй байгууллагын давхардсан тоогоор 7000 гаруй сурагч, 6000 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллийн хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. Мөн нөлөөллийн уулзалт 1, багш бэлтгэх сургалт 3 удаа зохион байгуулж, орон нутгийн удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагч, сурагчид, эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл 260 хүн хамрагдсан. -Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдвал зохих 4758 хүүхдээс 2543 хүүхэд хамрагдаж, хамралт 53,6%-д хүрсэн бөгөөд уг вакцины дархлаажуулалтад хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хариу арга хэмжээний үр дүнд 23,4%-иар хамралтын хувь нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна. -Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 3717 хүүхдээс 2519 хүүхдийг нөхөн дархлаажуулалт болон цахимд нөхөн бүртгэж, хамралт 70%-д хүрсэн бөгөөд хариу арга хэмжээний үр дүнд 38%-иар хамралтын хувь нэмэгдсэн байна.	
19	3.10.10.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг мэндийн байгууллагад бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах эрхийг бүрдүүлж ажиллана.	535,2 мянга ОНТ	Дэд бүтэц, хүртээмж ээр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын хувь	87%	90%	Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын 90%-д хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах гадна болон дотоод орчны тохижилт хийгдсэн үр дүнд хүрсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Үйлчлүүлэгч ба үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя” 2 сарын аяныг зохион байгуулж, нийт 32 эрүүл мэндийн байгууллага идэвхтэй оролцсон. Тус аяны хүрээнд -Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2025 оны А/237 тоот захирамж болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Орхон аймгийн салбар зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 32 эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд “Дохионы хэлний дунд шатны сургалт” сургалтад хамрагдаж сертификат гардан авсан. -“Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны үндсэн шаардлага” MNS 6055:2009 “Явган хүний зам, талбай төлөвлөлт техникийн шаардлага” MNS6808:52019 стандартын дагуу өөрийн эрүүл	100

						мэндийн байгууллагуудад дотоод болон гадаад үнэлгээг хийж, явган хүний налуу зам, замын бариул, хөгжлийн бэрхшээлтэй хүний авто машины зогсоол, зогсоолын тэмдэглэгээ зэргийг 18 эрүүл мэндийн байгууллага шинээр хийсэн байна. -Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг сайжруулах хүрээнд мэдээллийн самбар, шатны зөөлөвч, таяг, харааны шил, дуугүй хөтөч, ханын бариул, дуслын хонх, дуут дохио зэргийг 24 эрүүл мэндийн байгууллага нэмэгдүүлсэн байна. - Орон нутгийн 535,2 сая төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн бүх тасаг нэгжийн ариун цэврийн өрөөнүүдийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэн зассанаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлээд байна.Мөн явган хүний зам, авто зогсоол зэргийг шинэчлэн сайжруулсан. -Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудын 90 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3%-иар нэмэгдсэн байна.	
20	3.10.11.Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж, 1-2 Сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байгуулна		Сайжруулсан ариун цэврийн байгууламж бүхий эрүүл мэндийн байгууллагын хувь	100%	100%	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 176 эрүүл мэндийн байгууллага нь төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системд бүрэн 100% холбогдож, стандартын шаардлага хангасан сайжруулсан ариун цэврийн байгууламжтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Сумын эрүүл мэндийн 1 төвтэй бөгөөд төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системд бүрэн холбогдсон байна.	100
21	3.10.12.Алслагдсан эрүүл мэндийн төвүүдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нарны болон газрын гүний сэргээгдэх эрчим хүчийг ашиглан түүхий нүүрсний хэрэглээг 5-8 сумын эрүүл мэндийн төвд зогсооно.		Төвийн халаалтад хамрагдсан сумын эрүүл мэндийн төвийн хувь	100%	100%	Орхон аймгийн төвөөс 30 км-ийн зайд Жаргалант сумын эрүүл мэндийн төв бүрэн автомат эрчим хүчний нөөц үүсгүүртэй, төвийн нэгдсэн халаалт, төвлөрсөн усан хангамжид бүрэн холбогдсон. Тус төв нь нийт 2335 м2 эдэлбэр талбайтай, 774 м2 талбай бүхий өөрийн байранд тусламж үйлчилгээг үзүүлж байна.	100

3.11.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр

22	3.11.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын үнэлгээ хийж, үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	1.0 сая ОНТ	Стандартын хэрэгжилтийн хувь	80.5	85.8	Тайлант хугацаанд төр,хувийн хэвшлийн 32 эрүүл мэндийн байгууллагын "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS7014:2023 стандартын үнэлгээг 2 удаа хийж, хэрэгжилтийг хангах хүрээнд доорх ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: -Бүх шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудын дунд орон нутгийн 1.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Үйлчлүүлэгч ба үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя" 2 сарын аяныг зохион байгуулж, чанарын өдөрлөг 2, хэлэлцүүлэг 3, дэмжлэгт хяналт, үнэлгээ 4, сургалт 6, туршлага солилцох уулзалт 4 удаа зохион байгуулж, нэгдсэн үнэлгээгээр эхний 3 байранд Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн Талын булаг ортой клиник, Мөнхийн үйлс ортой клиник эхний 3 байрт шалгарсан байна. -Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт нэгдсэн чанарын өдөрлөг зохион байгуулж, ЭМБ-уудын 58 эмч, эмнэлгийн ажилтнууд хамрагдан чадавхжсан. -ЭМГ-ын дэргэдэх Сувилахуйн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан"Сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал-Тарилга хийх арга техникийг сайжруулах нь" сэдэвт хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн байгууллагуудын 41 арга зүйч, ахлах сувилагчийг хамруулан чадавхжуулсан. -“Халдварын сэргийлэлт хяналт,сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад анхаарах нь" сэдэвт салбарын дундын хэлэлцүүлэгт анхан, лавлагаа шатлал, хувийн хэвшлийн 40 эмч,мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулсан. -Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих стандарт MNS 7014:2023, Дохионы хэлний дунд шатны сургалт, Тарилгын аюулгүй байдал, Халдвар дамжих эрсдэл ба урьдчилан сэргийлэлт зэрэг 4 сэдвээр 166 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулан мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн. -Төр хувийн хэвшлийн 32 эрүүл мэндийн байгууллага аяны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүнг танилцуулан, Эмчилгээ чанарын алба, баг, сувилахуй, халдвар сэргийлэлтийн хяналтын баг, дотоод хяналтын багууд туршлага солилцож, -Аяны үр дүнд Эрүүл мэндийн байгууллагуудад дотоод болон гадаад орчны үнэлгээ хийгдэж, явган хүний налуу зам,замын бариул, хөгжлийн бэрхшээлтэй хүний автомашины зогсоол, зогсоолын тэмдэглэгээ зэргийг шинээр хийж, үйлчлүүлэгчдэд ээлтэй аюулгүй тав тухтай орчин бүрдүүлж, мэдээллийн самбар, шатны зөөлөвч, таяг, харааны шил, дуугүй хөтөч, ханын бариул, дуслын хонх, дуут дохионы хангалтыг Эрүүл мэндийн байгууллагууд нэмэгдүүлсэн байна.	100
----	--	-------------	------------------------------	------	------	---	-----

						-Эрүүл мэндийн цагаан толгой цуврал контентын 14 бичлэгийг Эрүүл мэндийн газрын пэйж хуудаст байршуулж, тайлант хугацаанд нийт 25124 хандалттай байна. -26 эрүүл мэндийн байгууллагад MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 85.8%-тай үнэлэгдэн, зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Уг стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрт хэвшүүлэх, сурталчлах нөлөөллийн арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, хяналт, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласнаар эрүүл мэндийн байгууллагуудын “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын хэрэгжилт 85,8%-д хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,3%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна.	
23	3.11.2. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, архаг өвчний хяналтын үзлэгийг чанаржуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, орон нутагт түр оршин суугч (отор), явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй түргэн шуурхай үзүүлнэ.		Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний дундаж хувь	90%	89.9%	Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 8 өрхийн эрүүл мэндийн төвтэй Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр үнэлэн зөвлөмж өгч, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Өрхийн эрүүл мэндийн 8 төвийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 89,9%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.8%-иар буурсан байна. Өвөрмөц үзүүлэлт буюу ЭМДЕГ-ын гүйцэтгэлийн үнэлгээгээр 95,5% гүйцэтгэлтэй байна. -Тусламж, үйлчилгээний үндсэн үзүүлэлт: Тайлант хугацаанд 1923 эх амаржсан ба үүнээс хяналтгүй төрөлт 10, амьгүй төрөлт 9, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.3 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 промиллээр буурсан байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 383,183 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 283573 (74.0%), гэрийн идэвхтэй хяналт 121391 (31.6%), гэрийн дуудлага 2618, бүртгэгдсэн өвчлөл 5869 байна. -Гэрийн идэвхтэй эргэлтийг 51,686 удаа үзүүлж өмнөх оны мөн үеэс 358 тохиолдлоор нэмэгдэж, 2501 өвчлөл шинээр бүртгэгдсэн. -Тайлант онд 8058 хүн диспансерын хяналтад байснаас 680 (8.4%) эдгэрч, 549 (6.8%) шилжиж, 144 (1.8%) нас барж, 1846 (22.9%) хүн шинээр авч оны эцэст 8531 хүн архаг хяналтад авсан байна. Хяналтад байгаа өвчлөлөөр авч үзэхэд артерийн гипертензи - 2241 (26.2%), гепатит - 1377 (16.1%), чихрийн шижин – 1150 (13.4%), хорт хавдар – 694 (8.1%) байна. -Явуулын, түр оршин суугч 4570 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй шуурхай үзүүлсэн. Тайлант хугацаанд 1313.mn сайтад 8 өрхийн эрүүл мэндийн төвд	100

						6705 иргэн үнэлгээ өгсөн ба дунджаар 3.6 (2.9-4.5)-тай, талархал-116, хүсэлт-7 байна. Сэтгэл ханамжийн судалгааг 444 хүн бөглөсөн. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв 1111, аймгийн ЗДТГ-ын иргэдтэй харилцах 70353511-т өрхийн эрүүл мэндийн төвтэй холбоотой 65 хүсэлт ирсэн нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буурсан байна. Үүнээс талархал -51 (80%), гомдол- 10 (15.3%), хүсэлт -3 (4.7%) эзэлж байна. -8 өрхийн эрүүл мэндийн төв ISO 9001:2015 ОУ-ын чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага стандартыг 100% нэвтрүүлж, баталгаажуулах аудитад хамрагдан гэрчилгээ авсан байна.	
24	3.11.3. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана.	5.0 сая ОНТ	Жирэмсний эрт хяналтын хувь	99.2%	99.0%	Тайлант хугацаанд жирэмсний хяналтад 1582 жирэмсэн эх хяналтад байгаагаас эхний 3 сартайд 1566 буюу 99.0 хувь нь хяналтад орж, өмнөх оны мөн үеэс 0,2%-иар буурсан. -Жирэмсний хяналтад 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдалт 93.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар нэмэгдсэн бөгөөд жирэмсэн үеийн гурвалсан халдварын илрүүлэг шинжилгээнд хяналтад байгаа жирэмсэн эхчүүдийг 100% хамруулснаас БЗДХ-ын шинжилгээнд трихомониаз 33 буюу 2.3 хувь, тэмбүү 10 буюу 0.7 хувь, заг хүйтэн 1 буюу 0.07 хувь тус тус эерэг гарч, төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдол бүртгэгдсэн. -Жирэмсний хяналтыг сайжруулах чиглэлээр салбар дундын хэлэлцүүлэг 2, дэмжлэгт хяналт 5, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварын үнэлгээ 1, чадавхжуулах сургалт 8 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор анхан болон лавлагаа шатлалын 98 эмч, эх баригч нарыг хамруулан чадавхжуулсан. -Анхан болон лавлагаа шатлалын 46 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ЭХЭМҮТ, БОЭТ-ийн төрөх тасагт ажлын байранд сэлгэн ажиллуулж чадавхжуулсан. -Эхээс урагт дамжих халдвар дамжих эрсдлийг бууруулах чиглэлээр тайлант хугацаанд бүртгэгдсэн төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдлыг ЭМС-ын 2019 оны А/614 дугаар тушаалын дагуу хэлэлцэж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв нь 16-49 насны түр оршин суугч, явуулын эмэгтэйчүүдийн судалгаанд тулгалт хийж, улирал тутамд шинэчлэн, жирэмсний нэрийн хяналт болон ЭМС-ын А/292 дугаар тушаалын дагуу сум, өрхийн эрүүл мэндийн 8 төвийн жирэмсний хяналтын мэдээ, жирэмсний тэмбүүгийн оношилгоонд сар бүр хяналт тавьж ажиллан, жирэмсэн эмэгтэйд хяналтад шилжүүлэхдээ гараас гарт зарчмын дагуу мэдээллийн урсгалыг сайжруулахад чиглэсэн хариу арга хэмжээг авч ажиллахад анхан болон лавлагаа шатлал, хувийн хэвшлийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа	99.8%

						холбоог нэмэгдүүлж ажилласан. -Амурлин Тэнгис ТББ, Мишээл МНЦО, хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн 6 клиниктэй хамтран зорилтот бүлгийн 1496 эмэгтэйг үзлэг шинжилгээнд хамруулж, трихомониаз, тэмбүү, заг хүйтэн эерэг илэрсэн 25 тохиолдлын хавьтлын судалгааг гарган, хавьтлын хамт 100% эмчлэн эрүүлжүүлсэн байна. Мөн БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд 812 эмэгтэйчүүд, эхо шинжилгээнд 711 охидыг хамруулж, 192 өвчлөлийг илрүүлж, эмчлэн эрүүлжүүлсэн. Тус үзлэгээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэлд 139 эмэгтэйг хамруулан, 5 сургуулийн 439 охидод эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна.	
25	3.11.4. Эх, нялхас, 5 хүртэлх насны нярайн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулж, эх, хүүхдийн эндэгдэлд судалгаа тогтмол хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана.	60,0 сая ОНТ	Эхийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд) 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	0 10.4	0 8.3	ЭМС-ын 2025 оны А/219 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2028 төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Орхон аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөөнд салбар байгууллагуудаас өгсөн саналыг тусган батлуулж, хэрэгжилт 94,6%-тай хэрэгжсэн байна. Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийг бууруулах 3 бүлэг,13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан 90.2%-тай хэрэгжсэн. Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр анхан болон лавлагаа шатлалын байгууллагууд, хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиникүүдтэй хийсэн хамтын гэрээнд заалтуудыг тусган, үр дүнг тооцож, удирдлага, эргэн мэдээллээр хангаж ажилласан. -Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, эмнэл зүйн удирдамж, тушаал зааврын хэрэгжилт, цаг үеийн болон хариу арга хэмжээ, хийгдсэн зохицуулалтын талаар сум, өрхийн эмч нарт 9 удаа мэдээлэл, чиглэл өгч, эх хүүхдийн тусламж үйлчилгээнд 4 удаа дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжийн хэрэгжилт 91,5%-тай байна. -Тайлант хугацаанд төрсөн 1923 нярайд эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг 100 хувь үзүүлсэн. Түнхний үений эхо оношилгоонд 1923, сонсголын скринингт 392, нүдний угийн улаан рефлексийг 1923, бодисын солилцооны скринингт 1516 нярайг хамруулсан. Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 23 нярайд хийж, 82.6%-ийн үр дүн өгсөн нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар нэмэгдсэн. -ЭМС-ын 2022 оны А/263 дугаар тушаалын дагуу 2025 онд бүртгэгдсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16, амьгүй төрөлт 9, гэрийн төрөлт 3, эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдлыг судлан магадлан хэлэлцэх зөвлөлөөр 4 удаа хэлэлцүүлж, гарсан 14 шийдвэрийн хэрэгжилт 85.6%, зөвлөмжийн хэрэгжилт 86.9%-тай	100

					байгаа бөгөөд хариу арга хэмжээний хүрээнд доорх ажлуудыг зохион байгуулсан.Үүнд: -2025 онд бүртгэгдсэн амьгүй төрөлт 9, гэрийн төрөлт 3, эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдолд дэлгэрэнгүй судалгааг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хожимдол үүсэхэд нөлөөлсөн шалтгаан, хүчин зүйлийг тооцон дүгнэлт, зөвлөмж боловсруулан ЭМБ-уудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. -Сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв нь 16-49 насны түр оршин суугч, явуулын эмэгтэйчүүдийн судалгаанд улирал бүр тулгалт хийж, сум,өрхийн эрүүл мэндийн төвийн эх баригч нараас жирэмсний нэрийн хяналт,ЭМС-ын А/292 дугаар тушаалын дагуу жирэмсний хяналтын мэдээг сар бүр авч, ЭМГ-аас хяналт тавин мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. -Жирэмсэн, эрт үеийн нярайн эндэгдлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан салбар дундын 2 удаагийн хэлэлцүүлэгт 71 эмч,эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. -ЭМЯ, ЭХЭМҮТ-өөс ЭМС-ын 2025 оны А/419, А/420 дугаар тушаалын хүрээнд “Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээ” сургалтыг Орхон аймагт 3 өдөр зохион байгуулж, БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, нярайн эмч, эрчимт эмчилгээний эмч, мэргэжилтэн 15 хүн, АШУҮИС-ын Дархан-Уул салбарын Эмнэл зүйн тэнхимтэй хамтран эх барихын яаралтай тусламж чиглэлээр 1 өдрийн онол, дадлага хосолсон сургалтад БОЭТ-ийн төрөх тасаг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 30 эх баригчийг хамруулан чадавхжуулсан. -ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭМГ-аас эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр зохион байгуулсан 10 удаагийн цахим, танхимын 16 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 530 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан байна. -Тайлант хугацаанд өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн боловсролын чиглэлээр 2, ургийн оношилгоо, ховор тохиолдлоор 2, төрөх, төрсний дараах тусламж үйлчилгээний чиглэлээр 2, эмэгтэйчүүдийн чиглэлээр 2 практик ач холбогдол бүхий 8 судалгаа хийгдэж, аймгийн эмч нарын эрдэм шинжилгээний хурал, өрхийн анагаах ухааны холбооны эрдэм шинжилгээний хурлуудад тэргүүн байр эзэлж, олон улсын хуралд ханан илтгэлийн хэлбэрээр судалгааны үр дүнг амжилттай танилцуулсан байна. -Тайлант хугацаанд орон нутгийн 30,0 сая төгрөгийн санхүүжилтээр төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Бүжинлхам эмнэлэгтэй хамтран зорилтот бүлгийн суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар, ус, агаараар эрүүлжүүлэн	
--	--	--	--	--	--	--

						чийрэгжүүлэх гэр сувилалд хамруулсан. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд орон нутгийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр 535 эмэгтэйд төмрийн бэлдмэл олгож, жирэмсэн, хөхүүл үеийн цус багадалтыг эмчлэн эрсдэл хүндрэлийг бууруулсан байна. -Эх,хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулахад орон нутгийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр иргэд, олон нийтэд чиглэсэн “Амьдралын алтан 1000 хоног” сургалт, нөлөөллийг ажлыг “Тогтвортой хөгжил ирээдүй” ТББ-тай хамтран 4 удаа зохион байгуулж, нийт 354 хүнийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. ЭМГ-ын цахим хуудсаар эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 7 постер, видео шторк 3, нийт 10 мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 18379 хүн үзсэн байна. -Тайлант хугацаанд эхийн эндэгдэл бүртгэгдээгүй, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.3 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 тохиолдлоор буюу 2.1 промиллоор буурсан нь улсын дундаж (16.8)-аас бага байна. -Тайлант хугацаанд нялхасын эндэгдлийн 15 тохиолдол бүртгэгдэж, 7.7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буюу 2.2 промилээр буурсан байна. Перинаталь эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж 8.2 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 9 буюу 4.1 промиллээр буурсан байна. Нярайн эндэгдлийн 11 тохиолдол 5.7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 буюу 2.7 промиллээр буурсан эерэг үр дүнд хүрсэн байна.	
26	3.11.5.Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжиж ажиллана.		Цогц үзлэгт хамрагдсан 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн тоо	2100	2284	Хүүхдийн тусламж, үйлчилгээнд бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх 9,18,36 сартай хүүхдийн цогц үзлэгийг тогтмол, тасралтгүй зохион байгуулж, нийт 2284 хүүхдийг хамруулснаас 79 хүүхдэд хөгжлийн хоцрогдлыг илрүүлж лавлагаа шатлалд илгээж, хяналтад авсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлж, тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/347 дугаар захирамжийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжсон.Тус комисс нь тайлант хугацаанд 21 удаа хуралдаж нийт 391 хүүхдийн асуудлыг хэлэлцсэнээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 168, боловсролд 55, сунгалт 89, цуцлагдсан 38, шинээр орсон 69, буцаагдсан 28, бусад 112 хүүхдийн асуудлыг	100

						шийдвэрлэсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлөөс салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах 3 удаагийн цахим сургалтад бүх гишүүдийг 100% хамруулан чадавхжуулсан байна.	
27	3.11.6.Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ.		Тээвэрлэсэн эхийн тоо	0	0	Тайлант хугацаанд төрсөн 1923 эхэд тусламж үйлчилгээг үзүүлснээс эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд тусламж үйлчилгээг орон нутагт багаар шуурхай үзүүлж, эхийн амь нас аврагдсан тул 3 дахь шатлалын эмнэлэгт тээвэрлэх тохиолдол гараагүй байна.	100
28	3.11.7.Эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Үндэсний багийг орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэн ажиллана	ОНТ 50.0 сая	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо	70	150	Тайлант хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан Үндэсний баг Орхон аймагт 2 удаа ажиллан ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, зүрх судас, хими эмчилгээ, элэг цөс, тархи мэдрэлийн чиглэлээр нийт 534 иргэнд үзлэг хийж, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах онол, дадлагат сургалтад давхардсан тоогоор 125 хүнийг хамруулан, хамтарсан үзлэг оношилгоо, хагалгаа хийж чадавхжуулсан байна.Үүнд: -Үндэсний багийн эмч нартай хамтарч элэгний мэс засал 4, ангио мэдрэлийн ТАСЕ 11 мэс заслыг хийсэн бол бие дааж элэг тайрах мэс засал 1, нойр булчирхайн мэс засал 1, ходоод тайрах мэс заслын-2, хөхний хавдрын мэс заслын 3 тохиолдлыг амжилттай хийгдсэн байна. -Үндэсний багийн эмч нартай хамтран 14 тархины судасны ангиографийн оношилгоо хийгдсэнээс тархины судасны аневризмийн 6, гүрээний судасны бөглөрөл ба нарийслын 1 тохиолдол тус тус шинээр оношлогдсон. - Орон нутагт нэвтрээгүй зарим мэс заслыг нэвтрүүлэх зорилгоор ШУГТЭ, УХТЭ-т хүсэлт хүргүүлэн гүрээний судасны бөглөрөл, нарийсалд стент тавих 1, судсан дотуур аневризм засах 1 мэс заслыг хамтран орон нутагт амжилттай хийгдсэн байна. -Доод мөчдийн их өнгөц венийн судсыг сугалж авах мэс заслын 7 тохиолдлыг бие даан амжилттай хийсэн. Үүнд 2 хүнд элэгний хавдрын судас бөглөх эмчилгээ, 3 хүнд элэгний хавдрын мэс засал, 30 хүнд хөхний үзлэг, оношилгоо, 3 хүнд хөхний мэс засал хийгдсэн. -Үндэсний багийн орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардалд орон нутгийн төсвөөс 50,0 сая төгрөгийг	100

						шийдвэрлэсэн байна. -Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр БОЭТ-ийн хавдар болон мэс заслын чиглэлээр нийт 3 эмчийг ХСҮТ-д нарийн мэргэжлийн сургалтад хамруулан хүний нөөцийг чадавхжуулсан байна.	
29	3.11.8.Баг, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг дулаан хувцсаар хангах, сумын Эрүүл мэндийн төвийн автомашины засвар үйлчилгээг шийдвэрлэн ажиллана.	2,0 сая	Хангагдсан автомашинны тоо	3	3	Жаргалант сумын Эрүүл мэндийн төвд 3 багийн эмчийг дулаан хувцас, ажлын хувцсаар 100% бүрэн хангасан. Жаргалант сумын Эрүүл мэндийн төвд бүртгэлтэй 4 автомашинаас 3 нь бүрэн ашиглагдаж байгаа, 1 автомашин актлуулах шаардлагатай байна. Орон нутгийн төсвөөр 2019 онд Musso, 2020 онд УАЗ пургон, 2022 онд Sonata 7, улсын төсвөөр 2024 онд олгосон түргэн тусламжийн бүрэн автомат Ланд крузер 78 автомашинаар алслагдсан бүс нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж ажилласан. Тайлант хугацаанд тус төв нь нийт 13155 үзлэг хийгдсэнээс гэрийн идэвхтэй хяналт 2395 (28.5%) хийж, 689 гэрийн дуудлага, үүнээс 163 алсын дуудлагын шатахууны зардалд 20,4 сая төгрөг зарцуулсан байна. Мөн автомашины засвар үйлчилгээнд орон нутгийн төсвөөс болон нэг иргэний санхүүжилтээр 100% шийдвэрлэж ажилласан байна.	100
30	3.11.9.Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжиж ажиллана		Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой бүртгэгдсэн тохиолдлын тоо	10	8	ЭМБ-уудын халдварын сэргийлэлт хяналтад 2 удаагийн дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч, халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах чиглэлээр салбар дундын хэлэлцүүлэг 2 удаа, аян 2, төвийн болон орон нутгийн 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 210 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан байна. -“Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя” 2 сарын аян, Дэлхийн гар угаах өдрийг угтан гар угаах 7 хоногийн аяныг тус тус өрнүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, аюулгүй байдлыг сайжруулах 7 зорилтын хүрээнд 22 хийх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилт 88,5%-тай хэрэгжсэн байна. -ЭМС-ын А/539 дүгээр тушаалыг сурталчлан таниулах, тандалт судалгааг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх ариутгал халдваргүйтгэлийн бодисын жагсаалтыг гаргах, нөөц хангалт хүртээмж, хэрэглээний байдал болон Эрүүл мэндийн 25 байгууллагын Халдварын сэргийлэлт хяналтын багуудын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	100

						Зөвлөмжийн хэрэгжилт 87,4%-тай байна. -Тайлант хугацаанд халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах чиглэлээр ЭМС-ын А/539 тоот тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд 18 эрүүл мэндийн байгууллага нийт 4 төрлөөр 52000 орчим үйлчлүүлэгчдэд тандалт хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэжигтэй 8 тохиолдлыг бүртгэн хариу арга хэмжээг авч ажилласан байна.	
31	3.11.10.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютер томографын аппарат, Ангиографын аппарат, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, ашиглалт, аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.	71,9 сая улс, ОНТ, гэрээт компани	Багаж тоног төхөөрөмжийн ашиглалт ад хийсэн үнэлгээн ий хувь	90%	92,3%	-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр баригдаж ашиглалтад орж, уг бэсрэг үйлдвэрийн засвар үйлчилгээнд хугацаат сэлбэг хэрэгслийг ажлын 40000 цаг тутамд нормын дагуу сольдог бөгөөд нэг удаагийн багц сэлбэгийн үнэ 19.9 сая төгрөгийн өртөгтэй байна. 2025 онд нормын дагуу хугацаат сэлбэг хэрэгслийг 6 дугаар сарын 19-нд Нью-терра бокс ХХК-тай хамтран сольж, бүх даралтын хэмжих хэрэгслийг “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-аар баталгаажуулж ажилласан. -Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн ангиографын тоног төхөөрөмжийн сэлбэгт 41.6 сая, ариутгалын плазм аппаратны сэлбэг хэрэгсэлд 10.1 сая, ариутгалын аппаратны сэлбэг хэрэгсэлд 3.4 сая, Line sencor 4.5 сая, дурангийн сэлбэг засвар үйлчилгээнд 12.3 сая төгрөг нийт 71.9 сая төгрөгийг улс болон орон нутгийн төсөв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төсвөөс шийдвэрлэснээр дээрх багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт сайжирч, тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн. -Компьютер томографын аппарат, ангиографын аппарат зэрэг дүрс оношилгооны өндөр өртөгтэй аппаратуудын тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэлтийн баталгаат хугацаанд нь “Medimpex” ХХК, “Setunagi” ХХК-тай хамтран үзлэг үйлчилгээ, урсгал засваруудыг тогтмол хийж ажилласан байна. -Баталгаат засвар үйлчилгээний хугацаа дууссан тохиолдолд засвар үйлчилгээг гэрээгээр хийх, үйлдвэрлэгч компанийн хяналт, сургалтад хамрагдан ажиллахаар нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. -БОЭТ-ийн ИТТ-ын 3 ажилтан 4 удаа мэргэжлийн чадавхжуулах сургалтад хамрагдан дээрх багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж ажилласан байна. -Багаж тоног төхөөрөмжийн ашиглалт 92.3%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.3%-иар нэмэгдсэн байна	100
32	3.11.11.“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай	3.2 тэрбум	Хэрэгжилтийн хувь	-	100%	Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гарган Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт хугацаанд нь хүргүүлж, худалдан авах ажиллагааг цахимаар зохион	100

	хууль"-ийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо, судалгааг гарган Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ					байгуулан tender.gov.mn-д сайтад худалдан авах үйл ажиллагааны бүх мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ил тод байдлыг ханган ажилласнаар хэрэгжилт 100%-тай байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс нийт 3.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 70 багцад худалдан авах ажиллагааг зохион байгуулж 4 багцын худалдан авах ажиллагаа амжилтгүй, 66 багцад 27 компани шалгарч гэрээ байгуулж сар тутам тасалдалгүй барааг нийлүүлэн ажиллаж байна.Тайлант хугацаанд 2.82 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бусад шаардлагатай барааг худалдан авсан. Ерөнхий гэрээгээр 18 компанитай гэрээ байгуулан нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 106 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахаар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 953.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл авсан байна. Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг төрийн өмчид шилжсэнтэй холбогдуулан тус эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг зохион байгуулж, нийт 211 нэр төрлийн эм, эмнэлгийн болон хувийн хамгаалах хэрэгслийг нээлттэй тендер зарласнаас цахим дэлгүүрээс 103 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг нийт 325.4 сая төгрөгөөр худалдан авсан байна.	
33	3.11.12.Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ	10,0 сая ОНТ	Цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамж	100%	100%	Тайлант онд БОЭТ-ийн Цусны салбар төв нь 10 нэр төрлийн 1504 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 17%-аар өссөн үзүүлэлттэй байна. Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээнд 688 донорыг 100 хувь хамруулснаас 3.7% нь халдвар эерэг гарсны улмаас хасагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өссөн. Тус төв нь одоогийн байдлаар сийвэнгийн 6 сар, цусны О-16, А-3, В-11, АВ-бүлгийн цусны 2 сарын нөөцтэй байна. Тайлант хугацаанд бүхэл цусны 403 донороос 403 нэгж цус цуглуулснаас байнгын 280 донороос 280 нэгж цус, шинэ 123 донороос 123 нэгж цус цуглуулсан байна. Нийт цус цуглуулалтын 68,1%-ийг суурин, 31,7%-ийг явуулын хэлбэрээр цуглуулсан байна. Цусны салбар төвд 2025 онд бүртгэлтэй байгаа 403 донорын цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, халдвар илрүүлэх шинжилгээнд 100% хамруулан баталгаажуулж, цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэл бүртгэгдээгүй байна. -Тайлант хугацаанд бүхэл цусны 668 донороос 668 нэгж цус цуглуулсны 540 суурин, 128 явуулын хэлбэрээр авсан.Орхон	100

						аймгийн Засаг даргын А/250 тоот захирамжийн хүрээнд 5 үйл ажиллагаа төлөвлөн биелэлт 97%-тай хэрэгжсэн бөгөөд “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх 3 зорилт, 13 үйл ажиллагааг төлөвлөн 100% гүйцэтгэж өдөрлөгт нийт 300-аад зочид төлөөлөгчид, хүндэт донор, идэвхтэн донор, байгууллага, иргэд оролцсон. -Орон нутгийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвхи санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулж, 8 байгууллагын 287 донор цус бэлэглэж, 7 байгууллагын 142 хүнд донорын ач холбогдлыг таниулах мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж, өмнөх оны мөн үеэс 37 донороор нэмэгдсэн байна.	
3.12.Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр							
34	3.12.1. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернет сүлжээнд холбоно	75.0 сая ОНТ	Мэдээлэл, сүлжээ программ д холбогдсон байгууллагын тоо	10	13	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн 161 Эрүүл мэндийн байгууллага интернэтийн сүлжээнд 100% холбогдсоноос 13 эрүүл мэндийн байгууллага Юнивишн, Мобинет ХХК-ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернэтийн сүлжээнд холбогдсон. - Интернетийн хурд сайжирснаар өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн цахим программуудыг өндөр хурдны интернетийн сүлжээгээр ашиглаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг ханган ажилласан. -Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ашиглаж буй E-Health цахим системийн хөгжүүлэлт тогтмол хийгдэж, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг тус системд холбосон. Мөн байгууллагын интернет хурдыг 100мб хурдтай байсныг 1гб болгон хурдыг 10 дахин нэмсэн. БОЭТ-ийн амбулаторийн цаг товлал, түргэн тусламжийн дуудлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хийгдэх программ хөгжүүлэлтийн төсвийг орон нутгийн төсвөөс 75 сая төгрөг гаргаж, программ хөгжүүлэлт 95 хувийн хэрэгжилттэй байна. -Тайлант хугацаанд мэдээлэл солилцооны нэгдсэн платформ НІЕР-д E-Health системд холбогдсон. Мөн дүрс оношилгооны PACS систем НІЕР системтэй холбогдон мэдээлэл солилцох боломжтой болсон. -Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ E-Mongolia системээс эрүүл мэндийн чиглэлээр 19 үйлчилгээг авч байна. -Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эрүүл	100

						мэндийн 8 төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвүүд нь 2 mb/ps хурдтай интернетэд холбогдсон байна.	
35	3.12.2. Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заасны дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж эрсдэлийн үнэлгээ хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.		Үнэлгээ хийлгэсэн байгууллагын тоо	-	1	-Тайлант хугацаанд Тагнуулын газартай хамтран эрүүл мэндийн салбарын 25 байгууллагуудад кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийж, мэдээллийн урсгалыг сайжруулах зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилт 81,8%-тай хэрэгжсэн байна. - Эрүүл мэндийн байгууллагууд мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр 100% хангагдсан. -Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн мэргэжилтэн, бүртгэл статистикийн ажилтнуудыг хамруулсан “Кибер аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлын тухай хууль” сургалтыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 35 хүнийг хамруулсан байна.	70
36	3.12.3.Кибер аюулгүй байдлын сургалтад Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтан, статистик мэдээллийн ажилчдыг улирал бүр хамруулна.		Хамрагдсан ажилтны тоо	10	76	-Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя” сэдэвт 1 сарын аяны хүрээнд Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан кибер аюулгүй байдлын сургалтад Эрүүл мэндийн 26 байгууллагын удирдлага, чанарын албаны дарга, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 65 хүнийг хамруулан чадавхжуулсан байна. -Төрийн цахим үйлчилгээний төвөөс зохион байгуулсан кибер аюулгүй байдлын сургалтад хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэл статистик хариуцсан 11 ажилтанг хамруулан чадавхжуулж, эргэн мэдээллээр тогтмол хангаж ажилласан.	100
37	3.12.4.Алсын зайн анагаах ухаан, телемедицины үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах тоног, төхөөрөмж хурдны интернэтээр ханган ажиллана.	30.0 сая ОНТ	Алсын зайн оношилго отелемед ицийн техник тоног	6	11	Тайлант хугацаанд телемедициний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: -Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 215 хүний мэдээллийг оруулсан. -БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсан бөгөөд 2025 онд нийт 21 өвчтөнд зөвлөгөө авсан байна.	100

			төхөөрөм ж бүхий байгуулл агын тоо			-Тайлант хугацаанд 48 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан дээд шатлалын эрүүл мэндийн байгууллагуудаас оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна. -Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд, 2025 онд орон нутгийн 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр 1 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологийг хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд мобайл технологиор гэрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэгт ашиглаж давхардсан тоогоор 10,000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна -Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдэд Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулсан нь нийт групп сунгуулагдагсдын 2%-ийг эзлэж байна. -Хувийн хэвшилд Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлэг нь умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хиймэл оюун ухааныг ашиглаж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 476 хүнийг хамруулан, эрүүл 329, хавдрын урьдал үе оношилогдсон 83, эмчилгээнд хамруулсан 64, лавлагаа шатлалд илгээсэн 35 байна. -Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмж бүхий Эрүүл мэндийн 11 байгууллага байгаа ба Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалт 33.2%-тай болж өмнөх оноос 0,2%-аар нэмэгдсэн байна.	
3.13.Хүний нөөцийн чиглэлээр							
38	3.13.1.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан,орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.	50.0 сая ОНТ	Хөтөлбөр ийн хэрэгжилтийн хувь	89,9%	90,6%	-Тайлант хугацаанд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарт 2089 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын 2025-2030 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 арга хэмжээ 8 шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 90,6%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,7%-иар нэмэгдсэн байна. - Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS5095:2017,Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS6330:2017 стандартын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөцийн хангалт 91.4%, эмч сувилагчийн харьцаа 1:1,4 байна. -Сум,өрхийн эрүүл мэндийн 9 төвд 181 хүн ажиллаж байгаагаас эмч 50, эмнэлгийн мэргэжилтэн 50 ажиллаж, хүний нөөцийн хангалт хүртээмж 100%-тай байна. -Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн	100

						40,5 сая төгрөгийн санхүүжилтээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны сургалтад хамруулсан байна.Үүнд: Солонгос улсын Бусаны Их сургуулийн эмнэлэгт зүрх судас, цээжний хөндийн мэс заслын чиглэлээр 2 эмч, “Эрүүл мэндийн аялал жуулчлалын экспо”-д 1 эмч, Киргизстан улсын Бишкек хотноо зохион байгуулагдсан “Хөнгөвчлөх эмчилгээний олон улсын удирдлагын сургалтад 1 эмч, АНУ-ын Харвардын сургалтын хөтөлбөрт 1 эмчийг тус тус оролцуулж, орон нутгаас 8.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож дэмжлэг үзүүлсэн байна. -Төрөлжсөн болон мэргэшүүлэх сургалт, нийгэмлэгийн хуралд давхардсан тоогоор 1956 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаж ур чадвараа нэмэгдүүлсэн. -Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн ажилтнуудын үндсэн цалинг 8%-иар нэмж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн. -Улаанбаатар хотоос гэр бүлээрээ шилжин ирж Жаргалант сумын эрүүл мэндийн төвд ажиллаж буй 2 эмчийг дотор болон хүүхэд судлал чиглэлээр үндсэн мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр сургаж, орон сууцаар ханган дэмжсэн,орон сууцны урьдчилгаа 30%-ийг тус сумын эрүүл мэндийн төвийн жолоочид, олон жил ажилласан 1 ажилтанд 13,8 сая төгрөг, Талын булаг эмнэлэг 2 ажилтандаа тус бүр 10 сая, Эрдэнэт Медикал 3 ажилтанд тус бүр 13 сая төгрөгийг тухайн байгууллагаас олгосон байна. Мөн ажилтны ар гэрийн гишүүдийн эрүүл мэнд болон хүүхдийн сургалтын төлбөр бусад урамшуулалд нийт 25.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. -Гадаад улсруу аялах эрхийн бичгээр Эрдэнэт Медикал 3 ажилтан, Очир Увидас эмнэлэг 13 ажилтнуудыг тус тус шагнаж урамшуулсан байна.Шилжин ирсэн 2 шинэ сувилагчийг “Шинэ сувилагчийг дадлагажуулах хөтөлбөр”-т хамруулж,ажлын байранд дадлагажуулсан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эрүүл мэндийн салбар байгууллагуудын 78,4% буюу 1639 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан, 13,7 сая төгрөгийн аминдэмжүүлэлтэд хамруулан дэмжлэг үзүүлсэн байна.	
39	3.13.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заалтын дагуу ахмад настныг		Хамрагдсан эмч,эмнэ	10	20	Тайлант хугацаанд хүний нөөцийн дутагдлыг нөхөх зорилгоор 50 ба түүнээс дээш настай ажилтантай байгууллагууд нийт 76 ахмадыг ажиллуулан ажлын байраар хангаж, хүний нөөцийн дутагдалтай	100

	ажлын байраар ханган, хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэн ажиллана		лгийн мэргэжилтний тоо			байдлыг шийдвэрлэн ажилласан. Эрүүл мэндийн 12 байгууллагад тэтгэвэрт гарсан их эмч 16, сувилагч 34 үйлчлэгч 15, лаборант 3, техникч 2 бусад ажилчид 6 ажиллан тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажилласан байна. Үүнээс сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 12, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 35 ахмад ажиллаж байна.	
40	3.13.3.Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэжил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн үр чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	76.0 сая ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	89,9	98.7	2024-2025 онд улсын төсвийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 82 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас улсын төсвийн санхүүжилтээр 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 3,2% нь суралцсан. Төлөвлөлтийн дагуу нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92.0% байна. Магистр, докторын сургалтад 14 мэргэжилтэн суралцаж үүнээс 5 нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр шинээр элссэн. БНСУ, Австри улсад нийт 5 мэргэжилтэн туршлага судалснаар гадаад сургалт хамрагдсан эмч нарын тоо өмнөх үеийн мөн үеэс 1.2%-иар нэмэгдсэн байна. Мөн улсын төсвийн санхүүжилтээр 16 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, чадавхжсан байна. -Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд орон нутгийн 76.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Үүнд: • Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2 төрлийн эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, нийт 22 байгууллагын 199 эмч, сувилагч, судлаачдын 49 илтгэлийг хэлэлцүүлсэн. • Төрөлжсөн болон мэргэшүүлэх сургалт, нийгэмлэгийн хуралд давтагдсан тоогоор 1956 эмч сувилагч нар хамрагдсан. • Солонгос улсын Бусаны Их сургуулийн эмнэлэгт зүрх судас, цээжний хөндийн мэс заслын чиглэлээр 2 эмч, “Эрүүл мэндийн аялал жуулчлалын эксдо”-д -1 эмч, Киргизстан улсын Бишкек хотноо зохион байгуулагдсан “Хөнгөвчлөх эмчилгээний олон улсын удирдлагын сургалтанд-1 эмчийг тус тус оролцуулж, орон нутгаас 8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. • Нэн шаардлагатай 6 мэргэшлээр 9 эмч, сувилагчийг сургасан. Үүнд: Өвдөгний үений мэс засал судлал, Эмэгтэйчүүдийн	100

						хавдар судлал, Ходоод, нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал, Хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал, - Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал судлал, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлал, хавдрын сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний сувилагчийг бэлтгэж байна. 1 эмч БНСУ-д өвдөгний үений мэс заслын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн байна. Япон, БНХАУ, Филиппин, Узбекистан, Энэтхэг, БНСУ зэрэг орнуудад эх барих, нярайн эмчилгээ, мэс засал, удирдлага, хараа зүй, бөөр, мэдрэл зэрэг чиглэлээр 27 эмч олон улсын сургалт, семинарт хамрагдан онол, дадлага хослуулан ур чадвараа дээшлүүлсэн байна. - Хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт 98.7%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.8%-иар нэмэгдсэн байна.	
41	3.13.4.БООТ-ийг ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх байгууллага болгон бэлтгэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.	78,0 сая ОНТ	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	13,6%	14%	-ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа "Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах" төслийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтад "Яаралтай тусламжийн сувилахуй"-аар 12, эрчимт эмчилгээний сувилахуй 4, нийт 11 эрүүл мэндийн байгууллагын 16 сувилагч суралцаж, амжилттай төгссөн. -Тус төслийн хүрээнд "Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр", "Эмнэл зүйн шатлал"-ийн хөтөлбөрийг Орхон аймагт улсын хэмжээнд анх удаа эхлүүлэн, хөтөлбөрийн хүрээнд хэлэлцүүлэг 4 удаа зохион байгуулж, 9 шинэ сувилагчийг хөтөлбөрийн дагуу ажлын байранд нь дадлагажуулсан. -Тайлант хугацаанд ажлын байрны болон алсын зайн 112 удаагийн сургалтад нийт 2075 мэргэжилтэн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. - 126 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулж, гадаад сургалтад багийн бага эмч 3, сувилагч 3, эмч 4, удирдах ажилтан 4 нийт 14 ажилтан хамрагдсан байна.Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14% болж, өмнөх оноос 0,4%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна. -Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сувилахуйн алба нь нийт 255 сувилагч, тусгай мэргэжилтний орон тоотойгоор ажиллахаас 196 сувилагч, 23 туслах сувилагчтай ажиллаж, нийт 18 сувилагчийн орон тооны дутагдалтай байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны хуралдаанаар анх туслах сувилагч ажиллуулах үйл ажиллагааны зардлыг дэмжсэнээр жил бүр орон нутгийн төсөвт Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 12 туслах	100

						сувилагчийн цалинг орон нутгийн төсвөөс шийдэн сувилахуйн тусламж үйлчилгээний ачааллыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн бодлого зохицуулалт хийгдсэн. - 2025 онд орон нутгийн 78.0 сая төгрөгийн санхүүжилтээр 12 туслах сувилагчийн цалингийн зардлыг шийдвэрлэснээр 8,829 иргэнд асаргаа, сувилгаа, 67 удаагийн сургалтаар 1,758 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан. -Туслах сувилагчийн тоо жилээс жилд тогтмол өсөж, сургалтад хамрагдан, өмнөх оноос 12 сувилагчаар нэмэгдсэн байна.Туслах сувилагч нар эрчимт эмчилгээ, төрөх, эмэгтэйчүүд, гэмтэл, хүлээн авах яаралтай тусламж, хүүхэд, хавдар, хөнгөвчлөх тусламжийн тасаг зэрэг тусламж үйлчилгээний ачаалал өндөртэй тасаг, нэгжүүдэд ажиллуулснаар сувилахуйн тусламж үйлчилгээний ачаалал буурч, үйлчлүүлэгчдэд үзүүлэх асаргаа, сувилгааны чанар, хүртээмж нэмэгдэж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшлэн, сувилагчийн нөөцийн дутагдлыг тодорхой хэмжээнд нөхөж чадсан зэрэг бодит үр дүн гарсан байна.	
3.14.Бусад үйл ажиллагааны чиглэлээр:							
42	3.14.1. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай (түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээний зардал) бусад дэмжлэгийг (Багийн эмчийн унааны шатахууны зардал) Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.	3.9 тэрбум ОНТ	Тогтмол зардал шийдвэрлэгдсэн байна.	100	100	2025 онд аймгийн ИТХ, Засаг даргын дэмжлэгээр орон нутгийн 3.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон аймгийн анхан болон лавлагаа шатлалын байгууллагуудад зайлшгүй шаардлагатай түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээ, бусад дэмжлэгийн зардлыг шийдвэрлэсэн байна. Үүнд: -Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төвийн тогтмол зардалд 1.2 тэрбум төгрөг -Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, лабораторийн тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр шарлагын аппарат-1, цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат-1, Мобайл технологи-1, иммунологийн аппарат-2, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдэл, поток, искра аппаратаар хангахад- 141,5 сая төгрөг -Алслагдсан Булаг багт байрлах Нийцэл өрхийн Эрүүл мэндийн төвд prius-30 автомашин 1 -25.0 сая төгрөг -Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2025 онд нийт 1,125.7 сая төгрөгийн санхүүжилт авснаас байр ашиглалттай холбоотой 1,033.4 сая төгрөг, урсгал засварт 92.3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус орон нутгийн төсвөөс шийдвэрлэн дэмжлэг үзүүлсэн байна.Үүнд: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ариутгалын газ плазма аппарат,эрчимт эмчилгээний тасагт мэдээгүйжүүлгийн аппарат - Компьютер техник хэрэгслээр хангах -825.0 сая төгрөг	100

						• БОЭТ-ийн түргэн тусламжийн дуудлага, цаг товллын үйл ажиллагааг цахимжуулах-75.0 сая төгрөг • Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаанд түргэн тусламжийн үйл ажиллагаанд нэмэлтээр 4 эмч, 4 жолооч нарын цалин болон шатахууны зардал, засвар үйлчилгээ- 378.0 сая төгрөг • Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 12 туслах сувилагчийн цалин-78.0 сая төгрөг -Аймгийн Засаг даргын аваарын зардлаас гемодиализийн тасгийн их засварт 543,0 сая, хагалгааны нэгдсэн тасгийн дээврийн засварт 89.9 сая, Хавдрын оношилгооны төвийн их засварт 350.0 сая төгрөгийг тус тус шийдвэрлэн засвар үйлчилгээ бүрэн хийгдэж, иргэдэд тав тухтай орчныг бүрдүүлж, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. -НЭМ-ийн ноцтой байдлын үеийн улаанбурхан, томуу томуу төст өвчний дэгдэлт, ХПВ-ын эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх багаж, оношлуур,илүү цаг, шатахуун, мэдээлэл сурталчилгааны зардал зэрэг хариу арга хэмжээг чадавхжуулахад орон нутгийн төсвөөс 129.1 сая төгрөгийг шийдүүлсэн байна. -Орон нутгийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр зорилтот бүлгийн 1150 хүн амыг эрт илрүүлэг үзлэгт хамруулан, хамралтын хувь 100 % байна.	
43	3.14.2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллана	6.0 ЗД-ын нөөц сан	Объектын хамралтын хувь, Албан шаардлагын хэрэгжилтийн хувь	100%	100%	Төлөвлөгөөт шалгалтад 98 объект, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 708 объект, нийт 806 объектыг 100 хувь хамруулсан. Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 98 объектын 4 хувь нь их эрсдэлтэй, 32 хувь нь дунд эрсдэлтэй, 64 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, хууль сахин мөрдөлтийн дундаж 86.0 хувь байгаа нь өмнөх оноос 3.0 хувиар нэмэгдэж зорилтот түвшинг хангасан үр дүнд хүрсэн. Хяналт шалгалтаар нийт 2583 зөрчлийг илрүүлэн 1191 буюу 46 хувийг газар дээр нь арилгуулан, улсын байцаагчдын хамтарсан 1392 заалттай 121 албан шаардлагаар 121 объектод хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулан хэрэгжилт 86,4 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 3,4 хувиар нэмэгдэж зорилтот түвшинг хангасан. Улсын байцаагчийн 98 дүгнэлт, 2 акт үйлдэж 2 объектын үйл ажиллагааг зогсоож зөрчлийг бүрэн арилгуулан, 20 аж ахуйн нэгж, 11 иргэн нийт 31 объектод 26.0 сая төгрөгийн торгууль, хохирол нөхөн төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, улсын төсөвт 100 хувь төвлөрүүлсэн. Мөн 8 төрлийн шинжилгээний 876 дээж авч шинжлүүлэн 48 шинжилгээний дүн шаардлага хангаагүй зөрчлийг халдваргүйтгэл, ариутгалыг хийлгэж бүрэн арилгуулсан ба 261 заалттай хамтарсан 9	100

						актаар хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 21 төрлийн 878.0 мянган төгрөгний 285 ширхэг эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнд акт үйлдэж хураан авч, 223.2 мянган төгрөгийн хэрэглэх хүчинтэй хугацаа дуусахад 2-10 хоног үлдсэн болон бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал алдагдсан, хугацаа дууссан 13 төрлийн 90 ширхэг 1.7 сая төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг газар дээр нь устгуулсан. -Хяналт шалгалтын дүнг Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлийн хурлаар 4 удаа хэлэлцүүлж эрсдэлийг бууруулах бодлого чиглэлийн 4 шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн. Засаг даргын зөвлөлийн хурлаар хяналт шалгалтад шаардлагатай 98 объектын болон нутаг дэвсгэрийн 5 байршлын хөрсний 6 төрлийн шинжилгээний 557 дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулах,хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах шинжилгээний зардалд 6.0 сая төгрөгийг Засаг даргын нөөцийн сангаас зарцуулсан. Дотоод хяналтыг сайжруулах салбарын сургалтад 440 объектыг хамруулж, шилэн хяналтын цахим системд мэдээллийн санг бүрдүүлсэн	
44	3.14.3.Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.5, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дэх хэсэгт Заасныг үндэслэн харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах, ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	83.4	84.5	-Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Ус хангамжийн цехийн Цэвэр ус хангамжийн хэсгийн 15 худаг болон 2,3,4 дүгээр ус өргөх станц, хотын насосны станц, төв усан сангийн оролт гаралтын ус, Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ий харьяа төвлөрсөн ба төвлөрсөн бус усны эх үүсвэр, ус түгээх байруудын нийт 102 цэгийн уснаас төлөвлөгөөний дагуу улирал тутамд шинжилгээнд хамруулж, улсын байцаагчийн 6 дүгнэлт гаргаж хүргүүлсэн.Үүнээс 14 усны дээж нь химийн шинжилгээгээр Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй буюу кальцийн ион, магнийн ион, хатуулаг өндөр байсан тул төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгуудад шүүлтүүр тавих, угаалга халдваргүйтгэл хийж давтан шинжилгээнд хамруулах талаар улсын байцаагчийн 2 дүгнэлт гаргаж хүргүүлэн давтан шинжилгээнд хамруулахад 11 цэг нь стандартын шаардлага хангасан. -Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын харьяа хүн амын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж болон Сэлэнгэ амралт аялал жуулчлалын цогцолборын цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас төлөвлөгөөний дагуу нийт 8 дээж авч хими, нян судлалын шинжилгээнд хамруулан шаардлага хангаагүй 3 дээжийг давтан шинжилгээнд хамруулж стандартын шаардлага хангуулан ажилласан. Шалгалтын хүрээнд Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн “Хүрээлэн буй орчинд	100

						нийлүүлэх цэвэрлэсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй 3 дүгнэлт, шаардлага хангасан 2 дүгнэлтийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ус хангамжийн цехэд хүргүүлэн ажилласан. -Стандартын шаардлага хангаагүй дээжийн хувь 37,5-тай байна.Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилт 84,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1%-иар нэмэгдсэн байна.	
45	3.14.4.Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана		Цахилгааны эх үүсвэрээр хангагдсан байгууллагын тоо	10	20	-Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь ХТП-214 дүгээр цахилгаан дэд станцаас салбарлан Эрдэнэт хотын төв цахилгаан шугамаас цахилгаан тэжээл авдаг бөгөөд “Эрдэнэт булган ЦТС”-тэй хийсэн гэрээний дагуу сар бүр тогтмол үзлэг хийж улирал бүр урсгал засвар үйлчилгээг хийж хэрэглэгч байгууллагын хувьд хөндлөнгийн хяналт тавин ажиллаж байна.Мөн эмнэлгийн цахилгааны хэвийн байдлыг ханган сар бүр үзлэг үйлчилгээ явуулж, холбогдох байгууллагын хяналтын дор урсгал засварыг тогтмол хийж гүйцэтгэж байна. -Цахилгааны нөөц, эх үүсвэрийн бэлэн байдлыг хангах чиглэлээр хоёр нөөц генераторын сэлгэн залгалтын системд хяналт тавьж, 100 литрийн нөөц шатахууныг бэлдэн ажилласан.Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 110 кватт-ын чадалтай 2 нөөц цахилгаан үүсгүүртэй бөгөөд 3 блокийн 13 тасаг нэгжийг аваарын үед цахилгаан тэжээлээр ханган ажиллах бөгөөд 2025 онд нөөц үүсгүүр нь нийт 8 удаагийн тасралтаар 5 цаг 40 минут ажилласан байна. -Цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлэх хүрээнд мэргэжлийн байгууллагаар 3 удаа шалгалт тохируулга хийлгэж 3 удаа ажиллагааны шалгалт хийсэн. Ажлын байран дахь аюулгүй ажиллагааны чиглэлээр тасаг нэгжийн 26 ажилтныг хамруулан сургалт зохион байгуулсан. -Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр хагалгаа, мэс заслын тоног төхөөрөмжүүдэд өдөр бүр шалгалт тохируулга хийж тэмдэглэл хөтөлсөн. Эрсдэлээс сэргийлэх чиглэлээр цахилгааны ил утсыг далд монтажтай болгох, өвчтөнүүдийн байнга харьцаж болох цахилгаан хэрэгслүүдэд өдөр тутмын хяналт хийж ажилласан. -Учралтбаяр ӨЭМТ 220 кВ цахилгааны эх үүсгэвэр шинээр нэвтрүүлж байгаа ба тохируулга хийгдсэн. Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв 10/хонда мотор/ цахилгааны эх үүсгэвэртэй бөгөөд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй гэрээ байгуулж, инженер техник ашиглалтын аюулгүй ажиллагааны	100

						заавраар хангаж, урьдчилан сэргийлэх үзлэг, урсгал засвар, техникийн завсар үйлчилгээ хийж, газардуулга, хүчдэл тогтворжуулан барих төхөөрөмжид хяналт хийж, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан ажилласан. -Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлгүүд 110 кВ цахилгааны эх үүсгэвэртэй, цахилгаан саатлын үед 24-48 цаг ажиллах боломжтой ба шатахуунаар цэнэглэн хэвийн ажиллах боломж бүрдсэн. -Хувийн хэвшлийн ортой 11 клиникийн цахилгааны нөөц эх үүсвэр 95,0%, эрүүл мэндийн салбарын цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдал 90% байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5.2%-иар нэмэгдсэн бөгөөд цахилгааны эх үүсвэрээр хангагдсан 20 эрүүл мэндийн байгууллага байна.	
46	3.14.5. Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу газар олгохтой холбоотой дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар барилга байгууламж барих газрын байршил тогтооход эрүүл ахуйн дүгнэлт гаргуулж байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллана		Дүгнэлт зөвлөмж өгсөн тоо	35	42	-Тайлант хугацаанд барилга байгууламжийн зураг төсөлд хяналт хийлгэхээр аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн албан хүсэлтийн дагуу загвар зураг 40, ажлын зураг 43 нийт 83 зураг төсөл хянаж, шаардлага хангасан улсын байцаагчийн дүгнэлт 42 гаргасан байна. -Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын хуралд ажиллах мэдэгдэл хуудасны дагуу нийт 31 хуралд гишүүнээр ажиллаж илэрсэн 112 зөрчил дутагдлыг саналын хуудаст тусган арилгуулж, ундны усны шинжилгээний дүнд үндэслэн 30 шаардлага хангасан дүгнэлт гаргаж, гүйцэтгэлийн хянан баталгаажуулж байнгын ашиглалтад хүлээн авсан байна. -Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах” гэсэн заалтыг зөрчиж зураг төслийг зохиоход эрүүл ахуйн дүгнэлт гаргуулалгүйгээр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн 5 иргэн, 1 аж ахуйн нэгжид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчлийн тухай хуулийн 6.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хялбаршуулсан журмаар 6 шийтгэлийн хуудас үйлдэн нийт 3.7 сая төгрөгийн торгууль тавьж, шийтгэлийг 100 хувь барагдуулан ажилласан.	100
47	3.14.6. Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын	6,9 сая төгрөг	Объектын хамрагдал т	100%	100%	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 8 удирдамжийн дагуу хяналт шалгалтад 444 объектыг 100 хувь хамруулж, нийт 631 зөрчлийг илрүүлэн 395 буюу 54.6 хувийг газар дээр нь арилгуулан 36 албан шаардлагаар 11 объектод хугацаатай үүрэг өгч биелэлт	100

	хяналтын 2025 онд хэрэгжуулэх хяналт шалгалтын төлөвлөгөө, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, харьяалах нутаг дэвсгэртээ илэрч буй зөрчил дутагдлыг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана	ОНТ				84.8 хувьд байгаа нь өмнөх оныхоос 4.8 хувиар нэмэгдэж зорилтот түвшинд хүрсэн үр дүнтэй байна. -Илэрсэн зөрчилтэй холбоотойгоор 5 аж ахуйн нэгж, 9 иргэнд 7.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч бүрэн барагдуулан, 6 дүгнэлт гаргаж, 261 заалттай хамтарсан 9 актаар хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 21 төрлийн 878.0 мянган төгрөгийн 285 ширхэг эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнд акт үйлдэж хураан авч, 223.2 мянган төгрөгийн хүүхдийн бэлэгт багцлахад хэрэглэх хүчинтэй хугацаа дуусахад 2-10 хоног үлдсэн болон болон бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал алдагдсан барааг газар дээр нь устгуулсан. -Наадмын талбай, нийтийн үйлчилгээг явуулах зам талбайн хөрсний халдваргүйтгэлийг 3 давтамжтай хийлгүүлж, хог хаягдлыг цэвэрлүүлж ачуулсан.Хими, хор, нян судлалын 8 төрлийн шинжилгээний 250 дээж авч, шинжлүүлэн, 18 сорилын дүн шаардлага хангаагүй зөрчлийг халдваргүйтгэл, ариутгалыг хийлгэж арилгуулж, Хяналт шалгалтын дүнг Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлж эрсдэлийг бууруулах бодлого чиглэлийн 4 шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн. -Дотоод хяналтыг сайжруулах салбарын сургалтад 342 объектыг буюу 77.0 хувийг хамруулж, шилэн хяналтын цахим системд мэдээллийн санг бүрдүүлсэн.	
48	3.14.7.Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд одоо хэрэгжиж байгаа болон шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, салбар дундын уялдааг ханган хамтарч ажиллана.	520.0 ОНТ	Хэрэгжилтийн дундаж хувь	95.0	96.5	-Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаал болон эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, тусламж үйлчилгээг сурталчлах, хэрэгжүүлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр зорилтот бүрэн хангаж нийт 8 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 37 аж ахуйн нэгж, байгууллага, 11756 иргэнийг хамруулан, салбар дундын уялдаа холбоог хангаж, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөг 15 удаа, “Эрдэнэт-Үйлдвэр” ТӨҮГ-ын FM радиогоор үйлдвэрийн нийт албан хаагчдад 6 удаагийн шууд нэвтрүүлэг, Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд талархлын аянаар 30 контент видео, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, цагаан тоосны дэгдэлтийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн үйл ажиллагаанд идэвхтэй хамруулах мэдээлэл түгээх зорилгоор 42 видео бичлэг, ХПВ-ийн дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Вакциндаа идэвхтэй хамрагдацгаая" 6 удаагийн цуврал контент видеог бэлтгэн ORKHON_EMG инстаграм хаяг, youtube сувгаар	100

					дамжуулан иргэд олон нийтэд түгээн сурталчилсан байна. -Улс орон даяар зохион байгуулагдаж буй эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт аймгийн 69955 иргэн хамрагдаж, үзлэгийн хамрагдалт 65.9 хувьтай байгаа нь улсын хэмжээнд 21 аймгаас хамрагдалтын хувиар тэргүүлж байна. -Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх” тухай Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын хамтарсан “Эрүүл шүд арга, хэмжээ” 2024-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Аймгийн ЗДТГ, ИТХ, Мишээл хүүхэд сан ТББ, Эрүүл мэндийн газар, Шүд холбоотой хамтран нийт 85 сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч, сум, өрхийн эрүүл мэндийн 8 төвийн эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, шүдний эмч, эрүүл ахуйч нарыг чадавхжуулан, 85 багц хэрэглэгдэхүүнээр хангасан. Шүд угаах 24/3 аяны хүрээнд 12766 хүнд сургалт зохион байгуулж, боловсролын байгууллагын 56, сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” аянд 248 хүүхэд 248 эцэг эх асран хамгаалагч 64 багшийн оролцуулан, 39 цэцэрлэг, 24 сургууль, политехникийн 1 их дээд сургууль 1 нийт 65 байгууллагын 1214 ажилчдад шүд угаах онол дадлага хосолсон сургалт зохион байгуулж, 45 хүүхдийн байгууллагад шүд угаах орчин бүрдүүлсэн байна. - ЭМЯ, ЭХЭМҮТ-ээс ирүүлсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ХГБЗХГ, БГ, ЦГ зэрэг салбар дундын байгууллагуудын оролцоотой зохион байгуулсан өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын аяны нээлтэд 120 ахлах ангийн сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл оролцож, 63 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт ЕБС-ийн ахлах ангийн 2582 сурагчид хамрагдаж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгосон байна. -Хүний папиллома вирусын эсрэг вакцины хамралтыг нэмэгдүүлэх аяны хүрээнд Дэлхийн дархлаажуулалтын 10 хоногоор “Дархлаажуулалтын ашиг тусыг хүн бүрт хүртээе” өдөрлөгийг Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Боловсролын газар, ерөнхий боловсролын 23 сургуультай хамтран зохион байгуулсан нөлөөллийн 24 удаагийн арга хэмжээнд 4500 гаруй сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл хамрагдсан. Мөн нөлөөллийн уулзалтад орон нутгийн удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн салбарын төлөөлөл 100, сурагчид, эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллөөс 200 багш бэлтгэн 23 сургууль бүртэй арга хэмжээг хамтран зохион байгуулж ажилласнаар хүний папиллома вирусын	
--	--	--	--	--	---	--

					эсрэг вакцины хамралт 52%-д хүрсэн байна. -Аймгийн ИТХ-ын 2024 оны 18/04 дугаар тогтоолоор батлагдсан “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах 2024–2031 оны хөтөлбөр” болон Засаг даргын 2025 оны А/205 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нөлөөллийн бүсэд амьдарч буй 1,866 иргэнээс эрсдэл өндөртэй 500 иргэнийг хяналтат үзлэгт хамруулан, Цагаан тоосны нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд ЗДТГ, Байгаль орчны газартай хамтран “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-ын 400.0 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, салбар дундын уялдаа холбоог хангаж ажилласан. -Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар батлагдсан орон нутгийн 110.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сараар Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй хүнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулахад ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, 29 багийн ажлын алба, БГ, СГ, ХГБХГ, ЦГ, ХХААГ болон төрийн бус 13 байгууллагатай хамтран ажилласан. -Аймгийн ИТХ, ЗДТГ, бусад төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан “Иргэдийн оролцоо-Төлөөлөгчийн манлайлал-Төрийн үйлчилгээ” нэгдсэн өдөрлөг арга хэмжээнд Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв оролцож, 10400 гаруй хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сургалт сурталчилгааны мэдээллийг хүргэсэн байна. - Эрүүл мэндийн газраас 2025 онд олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг 5 ӨЭМТ, БОЭТ-д нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээнд 20 сая төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр World standart conculting компанитай гэрээ байгуулан өрхийн эрүүл мэндийн 5 төв амжилттай нэвтрүүлэн анхан шатны 8 эрүүл мэндийн байгууллагууд ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог 100% нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 62.5%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна.		
49	3.14.8.Засаг даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлын хэрэгжилтийг хэлэлцэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн санал санаачилгатай	910,0 сая ОНТ	Хэлэлцүүлсэн арга хэмжээний тоо	2	6	Орхон аймгийн ИТХ-ын тогтоолоор батласан “Хүн амын бүлэг,нийгмийн салбарын хүний нөөцийн 2024-2028” хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбараас 2 зорилт, 7 үйл ажиллагаа, 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган 3 удаа хэлэлцүүлэн, эрт илрүүлэг үзлэг, оношилгооны явц, үр дүнг сайжруулах. БОЭТ-ийн цаг товлал. Кибер	

	ажиллана. •Эрт илрүүлэг үзлэг, оношилгооны явц, үр дүн •Цахимжилт, Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал; Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ; •Хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааны дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ				аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд БОЭТ-ийн чадавхыг сайжруулах, хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааны дэмжих чиглэлээр заалтуудыг тусган орон нутгаас шаардлагатай төсвийг батлуулан, хэрэгжилтийг Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт дунджаар 85,5%-тай хэрэгжсэн байна.Үүнд: -Зорилтот бүлгийн хүн амын дунд эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахад 60,0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж зарцуулан ажилласан. Эрт илрүүлэг үзлэгт эрэгтэйчүүдийн хамралтыг нэмэгдүүлэн нийт 9 удаагийн өдөрлөг арга хэмжээнд 3850 эрэгтэй, малчдын өдөрлөгт 100 хүн, сүрьеэгийн эрт илрүүлэгт эрсдэлт бүлгийн 1872 хүнийг хамруулсан үр дүнг танилцуулан, цаашид эрэгтэйчүүдийн дунд эрүүл зөв хооллолт, хорт бодисын хэрэглээ, донгийн эмгэгт өртөх нөлөөллийн судалгааг хийх, эрт илрүүлэг үзлэгийг явуулын хэлбэрээр түлхүү зохион байгуулах, сүрьеэгийн эрсдэлт бүлгийг зөв тодорхойлох судалгааг дэлгэрэнгүй гаргах, хяналтад авах эмчлэн эрүүлжилтийн хувийг нэмэгдүүлэх, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх зэрэг саналуудыг танилцуулж, аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө, Орхон аймгийн таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2025-2028 оны арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулан нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх, чадавхжуулах, эрүүл мэндийн байгууллагуудын цахимжилт, кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр 2026 оны орон нутгийн төсөвт 426,0 сая төгрөгийг суулгасан байна. Хавдрын эрт илрүүлэг үзлэгийн оношлуурт Баян-өндөр сумын ИТХ-аас 40,0 сая төгрөг шийдвэрлэн хавдрын илрүүлэг үзлэгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. -Цахим эрүүл мэнд төслийг хэлэлцүүлэн орон нутгийн 75,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдүүлэн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн 103 дуудлагын үйлчилгээний программ хангамжийг шинэчлэх ажлыг гүйцэтгүүлэхээр 2025.02.14-нд зарласан сонгон шалгаруулалтад “Эгософт” ХХК шалгарч, гүйцэтгэл хугацаандаа 100% хийгдсэнээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үндсэн сайтын танилцуулга ба үйлчилгээний заавар бүхий нийтлэлийн хандалт 2 дахин нэмэгдэж, иргэдийн эмнэлгийн мэдээлэл авах хүртээмж нэмэгдсэн байна. -Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой	100
--	---	--	--	--	--	-----

					байдлын нөөц хангалтыг нэмэгдүүлэх хүрээнд хариу арга хэмжээний санал, тулгамдсан асуудлыг АОК-оор 4 удаа хэлэлцүүлэн 141,0 сая төгрөгийг шийдүүлэн, хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлж ажилласан. -Төвлөрлийг сааруулах хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үүнд: Үндэсний багтай хамтарч ажиллах зардалд орон нутгийн төсвөөс 50,0 сая төгрөг, хавдрын тусламж үйлчилгээний хүлээгдлийг бууруулах зорилгоор БОЭТ-ийн дэргэдэх Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвийг байгуулах, засвар үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэн, тендэр зарлагдаж 100% гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. -Аймгийн ИТХ-аар өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээ, байршлыг хэлэлцүүлэн, шинээр 2 өрхийн эрүүл мэндийн төвийг байгуулах, үйлчлэх хүрээг 2025 оны 10 сарын 01-ны 03/47 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулснаар анхан шатлалын тусламж үйлчилгээний эрх зүйн чадамжийг сайжруулан хүртээмж нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна. -Гемодиализын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаан хэлэлцэн тус үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллаж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу гемодиализын тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувийн хэвшлийн байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2 удаа зарласнаар “Их шүүдэргэнэ” ХХК шалгарч 10 аппараттайгаар 2026 оны 2 сарын 1-нээс эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Тус ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн 560,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар БОЭТөвд засвар тохижилт хийгдэж байна. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааг дэмжих, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд 76,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн эмч, сувилагч, эх баригч зэрэг мэргэжлийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, алдаршуулах, хөгжүүлэх чиглэлээр 12 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжилд 112 удаагийн сургалтаар 2075 мэргэжилтнийг чадавхжуулж, 60 гаруй эмчийг төрөлжсөн болон гадаад сургалтад хамруулан,	
--	--	--	--	--	---	--

						хавдрын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн, эрүүл мэндийн салбарын ажилчдын сэтгэл зүйн байдал, ажлаас халшрах шинж тэмдгийг тодорхойлон, тогтвортой сэтгэл зүйтэй хамт олныг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн “Сэтгэл зүйн дархлаатай хамт олон” төслийн хүрээнд 11 эрүүл мэндийн байгууллагын 968 эмч, мэргэжилтэн сэтгэл зүйн асуумжид хамрагдаж, 11 ментор албан хаагч бэлтгэгдэн ажилласан зэрэг хүрсэн үр дүн, хэрэгжилт, цаашид тавих саналыг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан.	
4.Гэрээний хэрэгжилт, гэрээний тайлагналт							
50	4.1.Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.		Хүсэлтийн тоо	1	Тухай бүр	2025 онд ЭМЯ-нд 2 хүсэлтийг хүргүүлж 1 албан хүсэлт шийдвэрлэгдсэн, 1 албан хүсэлт шийдвэрлэгдэх шатанд байна. 2025 оны эхний хагас жилд байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн 10.5 сая төгрөгийн өр төлбөрийг Сангийн Сайдын 73-р журмын дагуу зардлын бүлэг хооронд шилжүүлэх саналыг Эрүүл мэндийн яаманд 2025 оны 7 сард саналаа хүргүүлж, 8 дугаар сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан 10,5 сая төгрөгийн өр төлбөрийг шийдвэрлүүлсэн. Мөн 2025 оны 12 сарын байдлаар үүссэн өр төлбөрийг шийдвэрлүүлэхээр Эрүүл мэндийн яаманд 12 сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах, зардлын бүлэг хооронд шилжүүлэх саналыг албан бичгээр хүргүүлээд байна.	100
51	4.2.Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна.	7.2 тэрбум ОНТ	Давхцал үүсгээгүй байх	0	0	Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд зураг төсөв, магадлангийн дүгнэлттэй Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөвтэй ажлыг тусган орон нутгийн саналд давхцал үүсгэхгүйгээр саналыг хүргүүлэн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж ажилласан. -Орон нутгийн хөрөнгө оруулалтаар их засвар болон тоног төхөөрөмжид шаардлагатай төсвийн саналыг хүргүүлж, нийт 7.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэн улс болон орон нутгийн саналыг давхцал үүсгэхгүйгээр санхүүжилтийг батлуулан ажилласан.	100
52	4.3. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллах Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4		Өр авлагагүй ажилласан байдал	-	-	Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн салбар байгууллагын хувьд 2024 оны жилийн эцэст нийт 2,9 тэрбум төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага нь 2,8 тэрбум, нийт 4,3 тэрбум төгрөгийн төгрөгийн өр төлбөрийг тайлагнаснаас ажилчин албан хаагчидтай холбоотой 332,2 сая төгрөг, эм	0

	болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож, тооцсон талаарх тайлангаа тухай бүрд нь төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.					эмнэлгийн хэрэгслийн өр төлбөр 2,8 тэрбум, бараа ажил үйлчилгээний бусад өглөг, байгууллагад төлөх өглөг нийт 425,5 сая төгрөг байгаагаас нийт авлагыг 2,8 тэрбум буюу 100%-иар бууруулан 28,1 сая төгрөгийн авлагатай үлдэлтэй үлдсэн байна. Өр төлбөрийн хувьд оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал нийт өр төлбөр 2 дахин буюу 4,1 тэрбум төгрөгөөр өсөж, нийт өр 8,4 тэрбум төгрөг байна. Нийт өр төлбөрийг задалбал: -Ажилчин албан хаагчидтай холбоотой өр төлбөр 2,6 тэрбум буюу оны эхнээс 7,8 дахин их -Эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөр өмнөх оноос үлдэгдлээс 1,5 тэрбум 60,7%-иар өссөн -Бусад бараа ажил үйлчилгээ, байгууллагад төлөх өглөг өмнөх оноос 0,9 тэрбум буюу 3,3 дахин тус тус өссөн байна. Үүссэн нийт өр төлбөрийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт улсын хэмжээнд тасарснаас шалтгаалан өр төлбөр хуримтлагдаж үүсээд байна.	
53	4.4.Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.		Тайлан хугацаан д хүргүүлсэн хувь	100%	100%	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамаарах орон нутгийн төсвийн байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитаар хянан баталгаажуулж, Эрүүл мэндийн салбарын санхүүгийн нэгдсэн тайланг гарган, Эрүүл мэндийн Сайдаас ирсэн албан хуваарийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 17-21-ны өдрүүдэд төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэл тайланд бүрэн нэгтгүүлж ажилласан. Нэгтгэл тайланд байгууллага тус бүрээр холбогдох анхан шатны баримт материалуудыг авч хадгаламжийн нэгж хэлбэрээр хүлээлгэн өгсөн.	100
54	4.5.Төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, хөрөнгө арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ.		Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлсэн тоо	Тухай бүр	Тухай бүр	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын багцад хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэс заслын вакум хагалгааны өрөө болгох ажил гүйцэтгүүлэхээр 1 тэрбум 398.0 сая төгрөгийн гэрээтэй ажил, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах гэрээгээр 738.836.1 сая төгрөгийн 11 төрлийн 13 ширхэг тоног төхөөрөмжүүдийг тус тус Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.	100

55	4.6.Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны дотор хүргүүлж байна		Эрх шилжсэн үйл ажиллагааны тоо	-	-	2025 онд Эрүүл мэндийн яамнаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт хийгдээгүй.	-
56	4.7.Хэрэгжүүлэгч нь хагас жилээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг 06 дугаар сарын 15-ны дотор, бүтэн жилээр гэрээний Гуравдугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагаа тус бүрийн биелэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ		Хугацаанд нь биелэлт хүргүүлсэн хувь	100%	100%	Эрүүл мэндийн сайд, Засаг даргын 2025 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын 23, нэмэлтээр 3 шалгуур үзүүлэлтийн 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 25-ны дотор хугацаанд нь хүргүүлж үнэлгээ хийлгэсэн. Эрүүл мэндийн яамнаас хийгдсэн үнэлгээ, ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудыг сар бүр мэдээллээр ханган, 12 заалтын дагуу арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилт 91,6%-тай хэрэгжсэн байна. Эрүүл мэндийн сайд, Засаг даргын 2025 онд хамтран ажиллах гэрээний Гуравдугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагаа тус бүрийн биелэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтэд АЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн жилийн эцсийн байдлаар 2027 оны оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	100
57	4.8.Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь харьяа нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төв, бусад харьяа эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж, тайлангаа Эрүүл		Хүргүүлсэн тайлангийн тоо	2	2	Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад нийт өрхийн эрүүл мэндийн 8 төвд хяналт шалгалтыг холбогдох хууль эрх зүй, журмын дагуу хийж гүйцэтгэн байгууллага тус бүрд хяналт шалгалтын дүн, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хяналт шалгалтыг 2026 онд дамжин хийгдэхээр удирдамж болон хяналтын төлөвлөлтийг боловсруулан батлуулж тус байгууллагад хүргүүлсэн байна. Мөн хяналт шалгалт дууссан байгууллагуудын тайлан мэдээг ЭМЯ-ны дотоод аудитын газар хүргүүлсэн.	100

	мэндийн яамны дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.						
Тав. Улсын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх							
58	5.1.Эрүүл мэндийн газрын санхүүжилтийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөв болон Сангийн сайдын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан олгоно.		Нэгдсэн дансаар санхүүжилт олгосон дүн	3,2 тэрбум УТ	2,9 тэрбум УТ	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/07 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн яамнаас сар бүрийн төсвийн хуваарийн дагуу батлагдсан санхүүжилтийг Сангийн яамны нэгдсэн дансаар дамжуулан авч сар бүрийн үйл ажиллагааг санхүүжүүлэн ажиллаж байна.2025 оны 12 дугаар сарын байдлаар нийт улсын төсвөөс 3,2 тэрбум төгрөгийн санхүүжилт авахаас 2,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.	100
59	5.2.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлнэ.		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын санхүүжилт олгосон дүн	-	27.7 тэрбум төгрөг ЭМДС	Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 оны 3-р улирлын байдлаарх авсан нийт гүйцэтгэлийн санхүүжилт 27,67 тэрбум төгрөг байна. Үүнд: 1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нийт 20.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос тусламж үйлчилгээ 19.3 тэрбум төгрөг, эрт илрүүлэг 614.8 сая, төр хариуцах эм 638.2 сая төгрөг тус тус олгосон байна. 2.Өрхийн эрүүл мэндийн 8 төвд нийт 6.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс тусламж үйлчилгээнд 1.8 тэрбум төгрөг, нэг иргэнээр 4.1 тэрбум төгрөг, шүд амны хөндийн тусламж үйлчилгээнд 200.0 сая төгрөг тус тус олгосон байна. 3.Сумын эрүүл мэндийн төвд нийт 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс нэг иргэнээр 758.5 сая төгрөг, тусламж үйлчилгээнд 241.5 сая төгрөг, шүд амны хөндийн тусламж үйлчилгээнд 1.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.	100
Хэрэгжилтийн дундаж хувь 95.2% /Үр дүнд хүрсэн/							

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Орхон аймаг

2026 оны 01 дүгээр сарын 08

Д/д	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2023)	Хүрэх түвшин (2025 он)	Хүрсэн түвшин (2025)	Тайлбар	Үнэлгээ хувиар
1.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	77.1	75.1	87.9	2025 онд артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 63414 хүн хамруулахаар төлөвлөснөөс 55755 /87.9%/ хүн хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 10.3%-аар буурч, хүрэх түвшнөөс 12.8%-иар нэмэгдсэн байна.	100%
2.	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 35 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	68.5	92.7	100.0	Тайлант хугацаанд чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны 41371 хүн хамруулахаар төлөвлөснөөс 42878 хүн буюу 100.0% хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 13.3%,хүрэх түвшнөөс 10.9%-иар тус тус нэмэгдсэн байна.	100%
3.	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	13943	17626	21622	2025 онд 30-60 насны 24454 эмэгтэйг үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 21622 хүн хамрагдаж өмнөх оны мөн үеэс 1302 хүн илүү хамруулсан байна.	100%
4.	Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	37.1	42.3	60.5	2025 онд умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 5764 эмэгтэйг хамруулахаар төлөвлөснөөс 3487 /60.5%/ эмэгтэй хамрагдаж, өмнөх оны мөн үеэс 34.4%-иар буурч,хүрэх түвшнөөс 18.2%-иар нэмэгдсэн байна.	100%
5.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	34.1	36.3	35.3	Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх үзлэг 283573 хийгдсэн нь нийт үзлэгийн 35.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 26.7%, хүрэх түвшнөөс 1.0%-иар буурсан байна.	54.3%
6.	В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	99.7	99.3	99.4	В гепатитын тунд 24 цагийн дотор 1936 төрсөн нярай дархлаажуулалтад хамрагдахаас 1925 нярай буюу 99.4 хувь хамрагдсан нь өмнөх оны түвшинд, хүрэх түвшнөөс 0.1%-иар буурсан байна.	75.0%

7.	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит хемофилусинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/	99.8	100.0	99.9	Тавт вакцинд 1752 хүүхэд хамрагдахаас 1751 хүүхэд буюу 99.9% хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.1%-иар нэмэгдэж, хүрэх түвшнөөс 0.1%-иар буурсан байна.	50.0%
8.	Улаанбурхан-гахайн хавдар–улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	99.5	100.0	99.9	2025 оны байдлаар УГУ вакцины бүрэн тунд 2009 хүүхэд хамрагдахаас 2006 хүүхэд буюу 99.9 хамрагдсан нь өмнөх оны түвшнөөс болон хүрэх түвшнөөс 0.1%-иар буурсан байна.	80.0%
9.	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	0.0	0.0	0.0	Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй.	100%
10.	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	8.1	9.1	7.7	2025 онд нялхсын эндэгдлийн 15 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7.7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдол буюу 2.2 промилл, хүрэх түвшнөөс 1.4 промиллээр тус тус буурсан байна.	100%
11.	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	5.4	6.9	5.7	2025 онд нярайн эндэгдлийн 11 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 5.7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.7 промилл, хүрэх түвшнөөс 1.2 промиллээр тус тус буурсан байна.	20.0%
12.	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	9.4	10.2	8.3	2025 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.3 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буюу 2.1 промилл, хүрэх түвшнөөс 1.9 промиллээр тус тус буурсан байна.	100%
13.	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	4.0	3.0	4.7	2025 онд амьгүй төрөлтийн 9 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 4.7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 тохиолдол буюу 0.7 промилл, хүрэх түвшнөөс 1.7 промиллээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.	0%
14.	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	98.5	100.0	99.0	2025 онд жирэмсний хяналтад шинээр 1582 эмэгтэйчүүд хамрагдсан ба эхний 3 сартайд 1566 /99.0%/ хүн хяналтад орсон ба жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.2%, хүрэх түвшнөөс 1.0%-иар тус тус буурсан байна.	33.3%
15.	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	6.4	6.5	8.0	Тайлант хугацаанд нийт 1923 эх амаржсанаас өсвөр насны төрөлт 76 буюу 1000 эмэгтэйд 8.0 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.8 промилл, хүрэх түвшнөөс 1.5 промиллоор өссөн дүнтэй байна.	100%
16.	Сүрьеэгийн өвчлөлийн	6.0	6.6	7.5	2025 онд сүрьеэ өвчний 80 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 7.5	100%

	түвшин, 10 000 хүн амд				промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 23 тохиолдол буюу 2.3 промиллоор буурч, хүрэх түвшнөөс 0.9 промиллээр өссөн дүнтэй байна.	
17.	Вируст гепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	0.7	0.3	0.4	Тайлант үнэлгээнд вируст гепатит өвчний 4 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 0.4 промилл байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд, хүрэх түвшнөөс 0.1 промиллээр буурсан байна.	82.5%
18.	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	19.9	16.6	15.9	Зүрх судасны өвчлөлийн шалтгаант нас баралтын 169 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 15.9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 16 тохиолдол буюу 1.7 промилл, хүрэх түвшнөөс 0.7 промиллээр тус тус буурсан байна.	100%
19.	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	11.6	13.9	14.1	Хорт хавдрын шалтгаант нас баралтын 150 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 14.1 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.4 промиллээр буурч, хүрэх түвшнөөс 0.2 промиллээр өссөн дүнтэй байна.	0%
20.	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	0.5	0.0	0.2	Амиа хорлож нас барсан 2 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 0.2 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буюу 0.1 промиллээр буурсан байна.	60.0%
21.	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд /Х40-Х49/	1.3	0.6	2.3	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын 24 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 2.3 промилл байгаа нь өмнөх оны оны мөн үеэс 7 тохиолдлоор буюу 0.7 промиллоор, хүрэх түвшнөөс 1.7 промиллээр тус тус өссөн байна.	0%
22.	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10 000 хүүхдэд, Т20-Т32)	18.5	11.2	16.0	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн 16 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 16.0 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор буюу 2.9 промилл, хүрэх түвшнөөс 4.8 промиллээр тус тус өссөн дүнтэй байна.	34.2%
23.	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хүүхдэд, V00-V99)	0.0	0.0	0.0	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тохиолдол бүртгэгдээгүй байна.	100%
24.	Үндэсний багийг дэмжиж ажилласан хөрөнгө оруулалт	0.0	350.0	350.0	Үндэсний багийг дэмжиж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хавдрын оношилгоо эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвийн засварт орон нутгийн төсвөөр 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.	89.7%

25.	Үндэсний багийг дэмжиж ажилласан санхүүжилт	0.0	50.0	50.0	2025 онд Үндэсний багтай хамтарч ажиллах дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсөвт 50.0 сая төгрөгийг тусгасан.Энэ дагуу Үндэсний баг 2 удаа орон нутагт ирж ажиллахад нийт 50.0 сая төгргийн санхүүжилт олгож дэмжиж хамтран ажилласан.	100%
26.	Зорилтот бүлгийн хүн амын эрт илрүүлэг хувиар	0.0	85	100	Зорилтот бүлгийн нийт 1150 хүн ам эрт илрүүлэг үзлэгт 100 хувь хамрагдсан байна.	100%
						68.5%

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

Г.ГАНСҮХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

Г.ЭРДЭНЭБУЛГАН

ТАЙЛАНГ ГАРГАСАН: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

О.БАТЦЭНГЭЛ

